



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНМЭГ	Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ББУ	Бүтцийн бус уураг
ББТ	Бичил биетний тэсвэржилт
ББЭЭ	Бичил биетний эсрэг бием
БММӨ	Бог малын мялзан өвчин
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДЗМОУБ	Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ЗӨСҮТ	Зооноз өвчин судлалын үндэсний төв
МААЭЗЭН	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх
МАЭМТХ	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
МАЭМХГ	Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газар
МАЭМГ	Мал амьтны эрүүл мэндийн газар
МОНҮМЭХ	Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭАЦТЛ	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
МЭБС	Мал эмнэлэг, биотехнологийн сургууль
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭТ	Мал эмнэлгийн тасаг
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний эгж
МЭЛ	Мал эмнэлгийн лаборатори
МЭХ	Мал эмнэлгийн хүрээлэн
МЭХЭҮГ	Мал эмнэлгийн хяналт, эрсдэлийн үнэлгээний газар
МЭЭАБГ	Мал эмнэлгийн эрүүл ахуй, баталгаажуулалтын газар
МЭЭАБГ	Мал эмнэлгийн эрүүл ахуй, баталгаажуулалтын газар
МЭНС	Мал эмнэлгийн нэгдсэн систем
МЭЦГ	Мал эмнэлгийн цахим гэрчилгээ
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НАМЭМТ	Ногоон алт-Малын эрүүл мэндийн төсөл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХААБ	Нэгдсэн үндэстний байгууллагын хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НМЭГ	Нийслэлийн мал эмнэлгийн газар
ОББХШАХ	Онцгой байдлын бэлэн байдлыг хангах шаталсан арга хэмжээ
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар

ОХУ	Оросын Холбооны Улс
САЗ	Стандарт арга зүйн зөвлөмж
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
СХЗҮТ	Стандарт хэмжилзүйн үндэсний төв
СХОГ	Санхүү хөрөнгө оруулалтын газар
СТГ	Санхүү төлөвлөлтийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗУГ	Төрийн захиргааны удирдлагын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн хорооны бодлого зохицуулалтын газар
УИХ	Монгол улсын их хурал
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
УОК	Улсын онцгой комисс
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАТӨ	Үхрийн арьс товруутах өвчин
РБУ	Роз бенгалийн урвал
ХААШУА	Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи
ХАБХААХА	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын алба
ХАСУМ	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААИС	Хүнс, хөдөө аж ахуйн их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХУ	Хавсран холбох урвал
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
ЦЭА	Цөмийн энергийн агентлаг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Д/д	Агуулга	Хуудас
1	Удиртгал	6
	МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР	
2	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малын эмчийн үзүүлэлт	6
3	Монгол улсад мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	6
4	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэл	15
5	Үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүл, тайван байдлыг баталгаажуулах	16
6	Халдваргүй өвчний мэдээ	16
7	Малын эмийн асуудал	16
8	Оролцоот эпидемиологийн тандалтын тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх	17
9	“Бичил биетний тэсвэржилтээс /ББТ/ сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” /2022-2025/-ий хэрэгжилтийг хангах	17
10	Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	17
11	Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл	18
12	ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулах	18
13	Мал эмнэлэг, ариун цэвэр, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн сарын аян	19
14	Халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	19
15	Шимэгчтэх болон халдваргүй өвчинтэй тэмцэх арга хэмжээ	19
16	Зэрлэг амьтны өвчнийг тандалт сэдэвт олон улсын зөвлөгөөн	20
17	ДМАЭМБ-ын Монгол улсын мал эмнэлгийн үйлчилгээний гүйцэтгэлийн явцын үнэлгээ	20
	МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР	
18	Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг удирдлага, зохион байгуулалтаар хангах	21
19	Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх	21
20	Махны үйлдвэрийн хяналт, цахим систем нэвтрүүлэх	23
21	Малын эмийн хяналт, захиргааны хэм хэмжээний сургалт	23
22	Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах	24
23	Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх	24
24	МЭНС-ээр олгогдсон цахим гэрчилгээнд хяналт баталгаажуулалт хийх	24
25	Лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний олголтод хяналт хэрэгжүүлэх	25
26	Нөөцийн махны чанар, аюулгүй байдлын хяналт	25
27	Малын эмийн чанар, аюулгүй байдал, хэрэглээнд тавих хяналт	25
28	Мал эмнэлгийн салбарын сургалт, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмын хэрэгжилт	26
29	Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажуулалт	26
30	Мал, амьтан болон тэдгээрийн гаралтай олон улсын мал эмнэлгийн экспорт, импортын гэрчилгээ олгох	27

31	Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улс орны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хүсэлтийг шийдвэрлэх ажлын хүрээнд	27
32	Малын шимэгчтэх өвчинтэй тэмцэх төлөвлөгөөт арга хэмжээнд хяналт тавих, үр дүнг үнэлэх	27
33	Мал, амьтны өвчингүй тайван байдлыг баталгаажуулах, халдварт өвчнийг эрт илрүүлэх арга хэмжээнд хяналт тавих, эрсдэлийг үнэлэх	28
34	Импортын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлийн задлан шинжилгээ	28
ТАРХВАР ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ЧИГЛЭЛЭЭР		
35	Өвчний мэдээ, тайлан	29
36	Лабораторийн тандалт, шинжилгээ	29
37	Мал эмнэлгийн тархвар зүйн судалгаа болон мал эмнэлгийн арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ	31
38	АНМЭГ-ын мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцийн тоон мэдээлэл	39
39	Амьд малд олгосон мал эмнэлгийн гэрчилгээний тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ /2020-2022 он/	39
40	Мал эмнэлгийн цахим гэрчилгээ (МЭЦГ)	40
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР		
41	Харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлага	42
42	Байгууллагын хүний нөөцийн удирдлага	42
43	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	42
44	Салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	43
45	Шагнал, урамшуулал	43
46	Өргөдөл, гомдолд хариу өгөх үйл ажиллагаанд хяналт тавих	43
47	Дотоод хяналт шалгалт	43
48	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	43
49	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах	44
50	Архив, албан хэрэг хөтлөлт	44
САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР		
51	Мал эмнэлгийн салбарын төсөв	45
52	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагаа	45
53	Мал эмнэлгийн салбарын үндсэн хөрөнгийн өөрчлөлт	46

УДИРТГАЛ

Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Алсын хараа 2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Малын эмийн үлдэгдлийн хяналт"-ын үндэсний хөтөлбөр, ХХААХҮЯ-ны баримталж буй бодлого, чиглэлийн хүрээнд мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, өвчингүй, тайван улс, бүс, нутаг, хот айл, аж ахуйн нэгжийг тогтоон баталгаажуулах үйл ажиллагаа, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлэг, хорио цээр, хязгаарлалтын хяналт, шалгалт зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх стратегийн зорилтуудыг тус газрын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

МЭЕГ 2022 онд 38 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, 2022 онд бодлогын баримт бичигт тусгагдсан 6, төрийн үйлчилгээ чанар, хүртээмжийг сайжруулах 1, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 10, хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 2, нийт 19 зорилт, 50 арга хэмжээг тусган төлөвлөж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

МЭЕГ 2022 онд 38 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, 2022 онд бодлогын баримт бичигт тусгагдсан 6, төрийн үйлчилгээ чанар, хүртээмжийг сайжруулах 1, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 10, хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 2, нийт 19 зорилт, 50 арга хэмжээг тусган төлөвлөж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. МЭЕГ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө ХХААХҮЯ-ны ХШҮДАГ/Хяналт шинжилгээ дотоод аудитын газар/-аас 81% үнэлэгдсэн бөгөөд 43 арга хэмжээ 100%, 5 арга хэмжээ 90%, 2 арга хэмжээ 70% хэрэгжилттэй байв.

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малын эмчийн үзүүлэлт

Монгол улсын 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 1.006 МЭҮН-д 860 малын их эмч, 504 малын бага эмч, 126 мал зүйч ажиллаж, нэг МЭҮН-д 61.2 мянга, нэг малын эмчид 45.1 мянган мал оногдож байгаа нь олон улсын дунджаас 5 дахин өндөр байна.


2. Монгол улсад мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

Монгол улсад 2022 онд мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчин (БММӨ), хонины цэцэг, үхрийн арьс товруутах (ҮАТӨ) зэрэг 4 төрлийн гоц халдварт өвчний нийт 562 голомт бүртгэгдэж, 370.645 толгой мал ил шинж тэмдэгтэй өвчилсөн.

Монгол улсад шүлхий өвчин жил бүр, БММӨ хонины цэцэг өвчин 2020 оноос бусад жил, шинээр гахайн африкийн мялзан өвчин 2019, ҮАТӨ 2021-2022 онд бүртгэгдсэн байна.

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин


Монгол улсад мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тохиолдол 2022 онд нийт 20 аймгийн 204 сумд 462 голомт бүртгэгдэж, 359.836 толгой мал ил шинж тэмдэгтэй өвчилснөөс 708 толгой мал үхэж, хорогдон 359.128 толгой малын шинж тэмдэг бүрэн арилсан байна. 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 1 дүгээр сард нийт 16 аймгийн 92 сумын 151 голомтод шүлхий өвчин гарч, хорио цээрийн арга хэмжээ үргэлжлэн хэрэгжиж байв (Зураг №1, 2).



Зураг №1, 2. 2021-2022 онд үргэлжилсэн голомтын зураглал

Дээрх тархварзүйн үечлэлээс харахад 2022 онд шүлхий өвчин 2 удаа томоохон дэгдсэн бөгөөд хамгийн томоохон дэгдэлт нь 1, 2 дугаар сард тохиож, улсын хэмжээнд бүх аймагт дамжин тархсан юм. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гоц халдварт шүлхий өвчнөөр 1 аймгийн 1 сум, 1 голомтод 16 толгой бог мал өвчилсөн байгаа бөгөөд үүнд хорио цээрийн арга хэмжээ авсан байгаа болно.

Монгол улсад шүлхий өвчний гаралт, тархалт 2019 он болон түүнээс өмнөх жилүүдэд ихэвчлэн өвлийн улирал буюу 1-3 дугаар сард хамгийн олон бүртгэгдэж байсан бол 2021 оны 10-12 дугаар сард хамгийн өндөр, 2022 оны 1-2 дугаар сард мөн өндөр байжээ (Зураг №3).



Зураг № 3. Шүлхий өвчний тархварзүйн муруй (2021-2022)

ДМАЭМБ-ын гишүүн орны үүргийн дагуу тус байгууллагын албан ёсны сайтын цахим системээр дамжуулан, 2021-2022 онд тус улсад бүртгэгдсэн шүлхий өвчний гаралтын тохиолдлын талаарх мэдээллийг илгээж, баталгаажуулан олон улсад нээлттэй мэдээлсэн.

Онош баталгаажуулалт: УМЭАЦТЛ-т оношлогдсон шүлхий өвчний оношийг ДМАЭМБ-ын лавлагаа лаборатори болох Прибрайтын судалгааны хүрээлэнд эдийн болон ийлдсийн сорьцыг илгээж, баталгаажуулах шинжилгээг хийлгэсэн. Тус судалгааны хүрээлэнгийн дүнгээр сүүлийн жилүүдэд Ази, зүүн өмнөд Азид тархаад буй шүлхий өвчний О хэвшлийн ME-SA дэд бүлгийн Ind-2001 ийлдсийн хэвшлээр үүсгэгдсэн болох нь тогтоогдсон. Дээрх ийлдсийн хэвшлээр үүсгэгдсэн өвчлөл нь Монгол улсад 2018-2022 онд жил бүр оношлогдож, баталгаажиж буй нь уг өвчний гаралт эндемик байдалд шилжих эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн болохыг харуулж байна.

ДМАЭМБ-ын лавлагаа лабораторийн шинжилгээний дүнгээс үзвэл, УМЭАЦТЛ-т хийгдэж буй шүлхий өвчний шинжилгээ, оношилгоо нь олон улсын түвшинд шуурхай найдвартай болохыг харуулж байна.

Прибрайтын судалгааны хүрээлэнгийн дүгнэлтээр Монгол улсад оношлогдсон шүлхий өвчний үүсгэгчийн хээрийн омгоос олон улсад вакцины үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа O 3039, O Manisa, O TUR/5/09, O1 Campos BG, O1 Campos BI төрлийн омгоор үйлдвэрлэгдсэн вакцин хамгаалах боломжтой болохыг тодорхойлсон.

Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ: Шүлхий өвчний гаралт Монгол улсын 20 аймгийг хамран тархсантай холбоотойгоор шат дараатай тооцоо, судалгаа, тандалт шинжилгээг системтэйгээр гүйцэтгэсэн. Тухайлбал, мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийг 2-4 дүгээр сард 4 удаа хуралдуулж, улс орны хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг хэлэлцүүлэн, тодорхой шийдвэрийг гарган хэрэгжүүлж ажилласан.

Шүлхий өвчний гаралт 2021-2022 онд нийт 20 аймгийн 204 сумын нутаг дэвсгэрийг хамран тархсан хүндрэлтэй нөхцөл байдал, вакцины хязгаарлагдмал нөөц зэргийг харгалзан, сүргийн дунд халдвар тархаах хамгийн өндөр эрсдэл бүхий мал болох үхэр, гахай, цаа бугын сүргийг хамруулан, улсын хэмжээнд хавар, намар 2 удаагийн давтамжит дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр, тактикийг боловсруулан, амжилттай зохион байгуулав. (Зураг №4).




Зураг №4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт

ОХУ-ын вакцин үйлдвэрлэгчтэй 2021 оны 12 дугаар сард байгуулсан 83/12 дугаар бүхий гэрээний дагуу 4 ээлжээр 4 цуврал бүхий 9.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий нийт 12.0 сая тун вакциныг хүлээн авч, дархлаажуулалтад шаардагдах вакцины нөөцийг бүрдүүлсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд УОК, УОК-ийн нэгдсэн штаб, тусгай чиг үүргийн болон мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог хангах зорилгоор холбогдох шийдвэрийг гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Шүлхий өвчний сүргийн түвшний халдварлалтыг тогтоох тандалт судалгааг улсын хэмжээнд гүйцэтгэсэн (Зураг №5, 6).



Зураг №5, 6. Халдвар илрүүлэх тандалтын сорьц бэлтгэсэн байршил

Халдварлалтын хувь буюу шүлхийн тархалтын түвшинг улсын хэмжээнд гаргахад 33.1% (95%-ийн үнэн магадтай: 28-36%) байна. Энэ нь 3 хот айл тутмын 1, 12 мал тутмын 1 нь халдвартай байна гэдгийг илтгэнэ (Зураг №6). Энэхүү ийлдэс судлалын лабораторийн шинжилгээ нь Монгол улсын хэмжээнд шүлхий өвчний халдварлалт өндөр (тархалттай) буйг нотолж байна.

УОК-ын нэгдсэн шуурхай штабаас аймаг, сумын онцгой комиссыг нэгдсэн удирдлага, аргазүйгээр ханган, хорио цээр, халдваргүйтгэл, дархлаажуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлж ажилласан. УОК-ын нэгдсэн штабаас өдөр бүр аймаг, сумын онцгой комисстой хамтран, цахим хуралдааныг зохион байгуулж, удирдлага, аргазүйгээр ханган ажиллав. УОК-ын нэгдсэн штаб, ОБЕГ, МЭЕГ, МХЕГ-ын удирдлага, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг 12 аймагт ажиллаж, удирдлага, зөвлөмж, чиглэлээр хангаж ажилласан болно.


УОК-ын 2022 он 02 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 01 дүгээр албан даалгавар, МЭЕГ-ын даргын 2022 оны А/46, А/49, А/52, А/77 дугаар тушаалаар хэрэгжилтийг хангаж ажилласан.

Дархлаажуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд ажилласан 1.104 ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймаг, сумын онцгой комиссоос (1.0 тэрбум хүртэл) зардлыг гаргаж, улсын хэмжээнд нэгдсэн цогц байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг өвчний гаралтын нөхцөл байдалтай холбоотойгоор 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Эхний ээлжинд өвчний голомтыг хумих, улсын хэмжээнд тархалтыг зогсоох зорилгоор 17 аймагт нийт 1.4 сая тун вакциныг 2022 оны 3 дугаар сард хуваарилан олгож, эрсдэлд

суурилсан дархлаажуулалтын арга хэмжээг 2022 оны 3-4 дугаар сард 17 аймгийн 62 сумын 2.2 сая толгой мэдрэмтгий мал, амьтан хамруулан, 95.8% гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна (Зураг №7, 8).



Зураг №7, 8. Дархлаажуулалтын зураглал

Дараагийн ээлжинд дархлаажуулалтыг УОК-ын 2022 оны 02 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 01 дүгээр албан даалгавар, МЭЕГ-ын даргын А/77 дугаар тушаалаар 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 9-ний өдрүүдэд улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулсан. Уг дархлаажуулалтыг 21 аймгийн 330 сумын 170 гаруй мянган өрхийн 4.2 сая толгой үхэр, 20,0 толгой гахай, 2.3 мянган цаа буга, 17.4 мянган хонь, ямаа буюу нийт 4.239.7 мянган толгой мал, амьтан хамруулан, 95.9%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэв.

Монгол улсын хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймаг, нийслэлийн 336 сум, дүүргийн давхардсан тоогоор 298.9 мянган өрхийн 15.0 сая толгой мэдрэмтгий мал, амьтан хамруулсан (Хүснэгт №1).

Хаврын дархлаажуулалт											
	Аймаг тоо	Сум тоо	Өрх тоо	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа	Гахай	Бод	Бог	Нийт
1	22	336	160,104	1,622	5,145,074	1,749,734	1,306,032	37,814	5,184,510	3,055,766	8,240,276
Нмарын дархлаажуулалт											
	Аймаг тоо	Сум тоо	Өрх тоо	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа	Гахай	Бод	Бог	Нийт
2	22	336	138,883	-	6,337,122	233,316	227,536	44,824	6,381,946	460,852	6,842,798
Нийт	22	336	298,987	1,622	11,482,196	1,983,050	1,533,568	82,638	11,566,456	3,516,618	15,083,074

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 онд хэрэгжүүлсэн дархлаажуулалтын үйлчилгээний хөлсний үлдэгдэл нийт 1.5 тэрбум төгрөгийг 2022 оны 1-3 дугаар сард олгосон бөгөөд 2022 онд таригдсан тарилгын үйлчилгээний хөлсөнд нийт 2.2 тэрбум төгрөгийг олгосон. 2022 оны 10-11 дүгээр сард таригдсан нийт 6.4 сая толгой мал сүргийг дархлаажуулсан тарилгын үйлчилгээний хөлс 2.3 тэрбум төгрөгийг 2023 оны 1 дүгээр улиралд олгохоор төлөвлөөд байна.


Улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулсан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын гүйцэтгэл дархлааны идэвх шалгах тандалт судалгааны лабораторийн шинжилгээний дүнгээр тандалтад хамрагдсан нийт үхэр сүргийн 96% (улсын

хэмжээнд) нь шүлхий өвчний эсрэг дархлаатай, 4 хувь нь дархлаагүй буюу хангалттай хамгаалалтгүй байна. Үүнд Завхан, Баянхонгор, Төв аймгууд багтаж байна. Дээрх цогц арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд шүлхий өвчний гаралт 99.0 хувиар буурч, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 16 тооны бог мал тусгаарлалтад байгаа бөгөөд мөн оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс хойш өвчлөл нэмэгдээгүй байна.

Хонины цэцэг өвчин

ОХУ-ын Монгол улстай хил залгаа мужууд болон БНХАУ-д хонины цэцэг өвчний гаралт бүртгэгдээгүй бөгөөд Монгол улсад 2021, 2022 онд зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын уулзвар орчмын сумдад давтан оношлогдож, тасралтгүй гарсаар байна.

Хонины цэцэг өвчнөөр зүүн болон төвийн бүсийн 4 аймгийн 10 сумын 15 голомтод 903 толгой хонь өвчилсөн. Өвчний тохиолдол Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн нутагт оношлогдсон нь тал хээрийн бүс нутгийн хонин сүргийн нягтрал ихтэй, отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн ихтэй байдал нөлөөлсөн байж болох талтай (Зураг №9).



Зураг №9. Хонины цэцэг өвчний гаралтын зураглал

2022 оны 12 дугаар сарын байдлаар хорио цээртэй аймаг, сум үгүй бөгөөд өвчний гаралт намжмал байдалтай байна.


Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ: Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд “Биокомбинат” ТӨХХК-д үйлдвэрлэсэн 2021 оны нөөц, 2022 онд худалдан авсан 165.0 сая төгрөгийн өртөг бүхий 3.0 сая тун вакцинаар дархлаажуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Уг арга хэмжээнд 4 аймгийн 14 сумын 4.661 өрхийн 2.3 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулсан. Тарилгыг хийж гүйцэтгэсэн 50 МЭҮН-д үйлчилгээний хөлс болох 584.2 сая төгрөгийг 2023 оны мал эмнэлгийн арга хэмжээний зардлаас олгохоор төлөвлөөд байна.

Бог малын мялзан өвчин (БММӨ)


Манай улсын говийн бүсийн аймгуудад 2021 онд БММӨ гарч байсан бол 2022 онд өмнөх жилүүдэд дархлаажуулалт хийгдэж байгаагүй төвийн бүсийн аймгуудыг хамран, 12 аймгийн 54 сум, 99 голомтод 292 өрхийн 13.909 толгой мал ил шинж тэмдэгтэйгээр өвчилж, 3.453 толгой

мал үхсэнийг устгасан байна. 2021 оны сүүлээр өвчний гаралт намжсан ч 2022 оны 2 дугаар сараас говийн болон төвийн бүсийн аймгууд, улмаар 8 дугаар сараас хангайн бүсийн аймгуудад дахин тархсан нь өвчинтэй тэмцэх арга хэмжээг хангалттай хэрэгжүүлж чадахгүй аймаг, сум дамжин тархах нөхцөлийг бүрдүүлээд байна (Зураг №10).




Зураг №10. БММӨ-ий тархварзүйн муруй

Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакциныг 2021 онд худалдан аваагүй, вакцины нөөц бүрдүүлж чадаагүй зэрэг нөхцөл байдлын улмаас 2022 оны 7 дугаар сар хүртэл өвчний гаралтыг хязгаарлах дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдээгүйгээс аймаг, сум дамжин, өвчлөл тархах эрсдэл бий болсон.



Зураг 11. Баримжаалсан тархалт (2022.06)



Зураг 12. Баримжаалсан тархалт (2022.10)

Дээрх зураглалаас харахад 6 дугаар сард говийн бүсийн аймгуудад уг өвчин өргөн тархсан бол 10 дугаар сараас төв болон хангайн бүсийн аймгуудад дамжин тархсан болох нь харагдаж байна (Зураг 11,12).

2022 оны 12 дугаар сарын байдлаар өвчин нийт 8 аймгийн 16 сумын 21 голомтыг хамраад буй бөгөөд 5.865 толгой мал өвчилж, 1.666 толгой малыг устгаж, 2.574 толгой мал тусгаарлалтад байна.

Өдөрт нэмж өвчлөх малын тоо 2022 оны 12 дугаар сарын сүүлчээр 200-500 хүртэл өсөж буй нь өвөл болж, малчид өвөлжөөндөө суурьшсан хэдий ч малын шилжилт хөдөлгөөн хийгдсээр байгаатай холбогдож байна.


Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ, үр дүн: Дэлхийд БММӨ-ийг 2030 онд устгах хөтөлбөр гарган ажиллаж байгаатай уялдуулан ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалаар “БММӨ-тэй тэмцэх стратеги”-ийг баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх дэлхийн болон Монгол улсын стратегид зааснаар өвчлөл гарсан бүс нутгийн мэдрэмтгий мал сүргийг 2 жил толгой дараалан дархлаажуулж, 3 дахь жилээс төл малыг дархлаажуулах байдлаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ стратегийн дагуу сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 25-30.0 сая тун вакцин шаардагдах тооцоо гарсан болно.

ХХААХҮ-ийн сайдын 2022 оны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нээлттэй тендерээр шалгарсан “Дээд эрхэт” ХХК-аас 354.6 сая төгрөгийн өртөг бүхий ОХУ-ын “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах холбооны улсын төв”-д үйлдвэрлэгдсэн 3.0 сая тун вакциныг 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авч, МЭЕГ-ын даргын 2022 оны А/182 дугаар тушаалаар эрсдэл бүхий 11 аймаг, 45 сумын 4.478 малчин өрхийн 3.0 сая толгой малд дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн 89 МЭҮН-д 651.2 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг олгож, үлдэгдэл 100.0 сая төгрөгийг 2023 оны мал эмнэлгийн арга хэмжээний зардлаас олгохоор төлөвлөөд байна.

Ухрийн арьс товруутах өвчин (YATӨ)

Монгол улсад үүсэн нөхцөл байдал: Дорнод аймгийн 6, Булган аймгийн 2, Сүхбаатар, Дорноговь, Увс аймгийн тус бүр 1 буюу нийт 5 аймгийн 11 сумд YATӨ оношлогдож, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан (Зураг №13).



Зураг №13. Оношлогдсон YATӨ-ий гаралт (2022 онд)

Улсын хэмжээнд 2022 онд нийт 21 голомтод 279 өрхийн 1746 үхэр, үүнээс 1255 толгой үхэр өвчний ил шинж тэмдгээр өвчилж, лабораторийн шинжилгээгээр баталгаажсан. Өвчилсөн үхрийг устгаж, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Увс аймгийн Давст сумд өвчилсөн 491 толгой үхэрт илэрхий шинж тэмдэг сул ирсэн тул хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэн, өвчилсөн үхрийн хорио цээрийн хугацаанд тусгаарлаж, мал эмнэлгийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Өвчлөл 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс хойш дахин илрээгүй байна.

Гоц халдварт өвчний дэгдэлтийн үеийн удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ: МЭЕГ-аас томилогдсон мэргэжлийн баг, Дорнод, Булган, Увс аймгийн МЭГ, ЗДТГ, сумдын Засаг даргын тамгын газартай хамтран, гоц халдварт ҮАТӨ-ий нөхцөл байдалтай танилцаж, дараах хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэн ажиллалаа.

1. Булган, Увс, Дорнод аймгийн тухайд өвчлөл гарсан сумдын нутаг дэвсгэр дэх үхэр сүрэгт эрүүл мэндийн үзлэг, тандалт хийж, тархвар зүйн байдлыг тодорхойлох үүрэг чиглэл өгч хэрэгжүүллээ.
2. Аймаг, сумын ЗДТГ, Онцгой комисс, МЭГ-тай хамтран ажиллаж, мэргэжлийн анги, мэргэжлийн багийг үүрэгжүүлэн, хүн, малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтад авч, хорио цээрийн бүсчлэл, тархвар зүйн зураглал гаргаж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл, мэдээллээр ханган нэгдсэн зохион байгуулалтад оруулсан (Зураг № 14).



Зураг № 14. Мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч байгаа нь

3. Хорио цээрийн бүсэд хяналтын постын хүн хүч, үзлэг тандалт, дархлаажуулалт хийх малын эмч, мэргэжилтний тоо хүрэлцээгүй, хяналтын постууд хүн хүчгүй, хяналт сул байсан тул АОК,



Зураг № 15. Мал эмнэлгийн хяналт хэрэгжүүлж байгаа нь

МЭГ-аас шаардлагатай хүн, хүчийг нэмэгдүүлэн дайчлан ажиллуулж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн (Зураг № 15).

4. Голомтын болон сэжигтэй бүсийн малчин өрх, малын тоо, дархлаажуулах зураглал, тооцооллыг нарийвчлан гаргаж, шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн, урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулсан.

5. Малчин бүртэй “Хариуцлагын гэрээ” байгуулсан.

Малын гоц халдварт ҮАТӨ-ий талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх тухай аймгийн онцгой комиссын шийдвэрээр 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд нийслэл болон бусад аймаг, сумдад амьд үхэр, болон үхрийн мах, түүхий эдийг тээвэрлэх, худалдан борлуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэхгүй байхаар шийдвэрлүүлсэн.

ҮАТӨ-өөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт:

Шинэ болон дахин сэргэж буй ҮАТӨ-өөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 1.1 сая толгой үхрийг хамруулж, 98.1 хувийн үр дүнтэй гүйцэтгэв.

МЭЕГ-ын даргын 2022 оны А/04 тоот тушаалаар, үнэлгээний хороог байгуулан хуралдуулж, ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А/375 тоот тушаалаар батлагдсан худалдан авах төлөвлөгөөний дагуу ОХУ-ын Бүх холбоотын мал амьтны эрүүл мэндийн хүрээлэнгийн төвтэй ҮАТӨ-өөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах гэрээ байгуулан, 1.2 сая тун вакциныг худалдан авч, нөөцийг бүрдүүлсэн. Мөн ОУАЦЭА-ын тусламжаар (*Neethling*) омог 500 мянган тун вакциныг хүлээн авч, ҮАТӨ-өөс сэргийлэх бэлэн байдлыг хангаж ажиллалаа.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэл

2022 онд 18 нэрийн вакцинд давхардсан тоогоор 23.2 сая толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 2022 оны жилийн эцсийн мэдээгээр 22.2 сая толгой мал, амьтныг хамруулж, 96.2%-тай гүйцэтгэсэн байна.

Уг дархлаажуулалтыг Сүхбаатар аймаг хамгийн өндөр буюу 104.4% /нөөцөөс галзуугийн вакцин олгосон/, Архангай аймаг хамгийн бага буюу 73.9%-ийн гүйцэтгэлтэй байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЕГ-ын даргын 2022 оны А/166 дугаар тушаалаар батлуулж, улсын хэмжээнд 12.9 сая толгой мэдрэмтгий малын охин төл /эм тугал, хурга, ишиг/-ийг дархлаажуулах ажлыг 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлсэн. Малын бруцеллэзоос сэргийлэх дархлаажуулалтад 12.9 сая толгой охин төл /тугал, хурга, ишиг/-ийг хамруулахаас 12.3 сая толгойг хамруулж, 95.7%-тай гүйцэтгэсэн.

Хээлтүүлэгч малын бруцеллэзын тандалт

Хээлтүүлэгч малын бруцеллэзын тандалтад төлөвлөснөөр нийт 325 сум дүүрэг, 1236 баг, 55053 өрх, 55053 өрхөд хамаарах 381465 хээлтүүлэгч мал хамруулахаас 325 сум дүүрэг, 1236 баг, 55053 өрх айлаас 287269 дээж авч, гүйцэтгэл 75.3% дүнтэй буюу өрхийн тоо олон хамрагдсан дүнтэй гарсан. Хээлтүүлэгч малын статистик тоо хол зөрүүтэй, хорогдох, зарах зэргээс шалтгаалан тоонд хүрэхгүйгээс сүү нийлүүлдэг өрхийн үнээ, хонь, ямаа зэрэг 3 аймгийн нийт 1818 хээлтэгч (Дархан-Уул-309 үнээ, Дорнод-143 үнээ, Дорноговь-603 хонь, 763-ямаа) мал, нийт дүнгээр 287269 мал хамруулсан бөгөөд нийт хамруулсан малын гүйцэтгэл 75.3% байна. Нийт гүйцэтгэлийг авч үзвэл 36.16-84.96% бөгөөд малын төрлийн хувьд буур-53.3%,

бух-36.16%, хуц-80.03%, ухна-84.96% орчим хамруулсан дүнтэй гарсан байна. Ийлдэс судлалын шинжилгээгээр эерэг гарсан бух, хуц, ухныг нядалж хэрэгцээлэв.

Энэхүү тандалтаар нийт 20 аймаг, нийслэлийн хээлтүүлэгч малд хийсэн бруцеллёзын ийлдэс судлалын шинжилгээнд нийт 287269 дээж шинжлэгдсэнээс илрүүлэх РБУ, ЭЛИЗА-аар 0.13% буюу 395 нь эерэг буюу эсрэг биом илэрсэн дүнтэй гарсан байна. Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод аймгуудын хээлтүүлэгч малд бруцеллёзын эсрэг биом илрээгүй, бусад 17 аймаг, нийслэлийн хээлтүүлэгч малыг төрлөөр авч үзвэл нийт шинжлэгдсэн буур 0% (0/1824), бух 0.36% (77/21305), хуц 0.14% (211/143425), ухна 0.11% (128/118897)-д нь тус тус бруцеллёзоор эерэг буюу эсрэг биом илэрсэн байна. РБУ-аар нийт эерэг 0.15% (422/287269) эсрэг биом илэрсэн болно.

Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод аймгийн хээлтүүлэгч мал бруцеллёз өвчнөөр тайван байна. Малын төрлөөр авч үзвэл нийт шинжлэгдсэн буур 0% (0/1824), бух 0.14% (31/21305), хуц 0.06% (81/143425), ухна 0.03% (36/118897), 1.32% хээлтэгч (үнээ-6/452) нь тус тус бруцеллёзоор эерэг буюу эсрэг биом илэрсэн байна. Баталгаажуулах ХХУ-ын шинжилгээгээр 0.01%(154/287269) нь эерэг дүн үзүүлсэн.

Халдварлалтын 2011 оны суурь түвшнээс тооцож үзэхэд тэмээ, үхэр, хонь, ямаанд халдварын түвшин адил буурсан байна. Бруцеллёзын стратеги хэрэгжиж эхлэхээс өмнөх 2011 оны бруцеллёзын халдварлалтын түвшин 2011 онд 0.97%-тай байсан бол 2022 онд 0.10% болж, 0.87%-аар буурсан байна.

4. Үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүл, тайван байдлыг баталгаажуулах

“Монгол улс үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт”-д 2021 онд Монгол орны аймаг, нийслэлээс цуглуулсан 2500 ийлдсийн дээж, 2022 онд шүлхий өвчний тандалтын чиглэлээр эпидемиологийн тооцоололд тулгуурлан цуглуулсан 2500 дээж болон 2022 онд саалийн механикжсан фермийн аж ахуй хөгжсөн 4 аймаг, нийслэлээс нийт 1250 дээж ашиглан, 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв. Дээрх гэрээний 2.2-т заасны дагуу гүйцэтгэгч нь захиалагчийн өгсөн тоо хэмжээний хүрээнд буюу нийт 6250 дээжинд сүрьеэ, лейкоз өвчний ийлдэс судлалын шинжилгээ хийсэн бөгөөд бүгд сөрөг дүнтэй, гүйцэтгэл 100% байна.

5. Халдваргүй өвчний мэдээ

Улсын хэмжээнд 2022 онд нийт 23.3 мянган толгой мал, амьтан халдваргүй өвчнөөр өвчлөн, 1.4 мянган толгой мал хорогдож, 21.8 мянган толгой мал эдгэрсэн байна.

Халдваргүй болон шимэгчтэх өвчний чиглэлээр шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагатай хамтран судалгааны ажил хийхээр төсөвт 280.0 сая төгрөг суулгах санал оруулсан боловч 4 төрлийн гоц халдварт өвчин гарсантай холбоотой хасагдсан болно.

6. Малын эмийн асуудал

Малын эмийн салбар зөвлөлийн хуралдаан:

Мал эмнэлгийн зориулалттай мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч тусгай зөвшөөрөлтэй 102 аж ахуйн нэгж, мал амьтны эмийн улсын бүртгэлд 1072 малын эм, вакцин, тэжээлийн нэмэлт бэлдмэл бүртгэлтэй байна. Малын эмийн салбар зөвлөлийн 8 удаагийн

хуралдаанаар 2022 онд 10 аж ахуйн нэгжид шинээр мал эмнэлгийн зориулалттай мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч тусгай зөвшөөрөл олгож, 23 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгаж, 111 малын эм, тэжээлийн нэмэлтийг шинээр малын эмийн улсын бүртгэлд бүртгэж, 26 малын, эм тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэлийг сунгасан байна.

Малын эмийн үлдэгдлийн хяналт, баталгаажуулалт:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр, “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” 2022-2025 зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

7. Оролцоот эпидемиологийн тандалтын тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх

Мал, амьтны гоц халдварт өвчний халдварын тандалтыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйгээр, улсын хэмжээнд тогтмол хэрэгжүүлэх, дэгдэлтийг аль болох эрт илрүүлэх, тэмцэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлдэг байх шаардлага мал эмнэлгийн салбарт тулгарч байна.

Малын эмч нарт эрт илрүүлэг, оролцоот эпидемиологийн арга зүйгээр мал, амьтны гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах арга зүйг эзэмшүүлэх сургалтыг МААЭЗЭН төсөл, ДЗМОУБ-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд МААЭЗЭН төсөл, ДЗМОУБ-тай хамтарсан 3 ажлын хэсэг 6 дугаар сарын 19-29-ний өдрүүдэд 20 аймаг, нийслэлд “Мал амьтны гоц халдварт өвчний эрт илрүүлэг, оролцоот эпидемиологийн тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх” сургалтыг зохион байгуулж, уг сургалтад 879 мэргэжилтнийг хамрууллаа.

8. “Бичил биетний тэсвэржилтээс /ББТ/ сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” /2022-2025/-ий хэрэгжилтийг хангах

ББТ болон ББЭЭ-ийн хэрэглээг төлөвшүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд:

- Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хүнсний хангамж аюулгүй байдал-Мал аж ахуй” үндэсний чуулганд оролцогч 800 малчин иргэнд эмийн зохистой хэрэглээ, ББТ, эмийн үлдэгдлийн талаар мэдлэг, мэдээлэл хүргэсэн.
- Малын эмийн санчдын итгэмжлэл олгох сургалтын хөтөлбөрт эмийн үлдэгдэл, ББТ, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг сэдвүүдийг тусгаад байна.
- Малын эмч нарын говийн, баруун, зүүн болон төвийн бүсийн зөвлөгөөнд оролцож буй 745 малын эмчид сургалт, мэдээлэл хүргэж ажиллав (Баянхонгор, Завхан, Дорнод, Булган).
- “ББТ-ийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах дэлхийн 7 хоног”-ийг тэмдэглэн нэвтрүүлэг, видео шторк, цахим сургалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

9. Малын эмийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

- МЭЭГ-ын захиалгаар УМЭАЦТЛ-оор 2022 онд АНМЭГ-ын мах бэлтгэх үйлдвэрээс малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 262 дээжид малын эмийн үлдэгдлийн илрүүлэх түвшний тандалт шинжилгээг хийсэн. Шинжилгээний дүнд дээрх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдол илрээгүй байна.

- МААЭЗЭН төсөл, ДЗМОУБ, МЭЕГ, АНМЭГ-ын мал эмнэлгийн улсын байцаагч, халдвартын эмч нийт 44 албан хаагчийг 2022 оны 4 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Малын эмийн үлдэгдлийн үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилт”, “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалтуудад хамруулав.
- “Үндэсний мал эмнэлгийн холбоо” ТББ-тай хамтран МЭҮН-ийн болон эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч эмч нарт зориулсан шаталсан сургалтаар "Малын эмийн үлдэгдлийн хяналт" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, “Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх салбар дундын төлөвлөгөө”-ний хэрэгжилт, хэрэгжүүлэхэд та бүхний оролцоо, “Малын эмийн зохистой хэрэглээ” цахим сургалтыг 2 удаа зохион байгуулав.
- Мал амьтны гаралтай экспорт, импортын түүхий эд, бүтээгдэхүүнд антибиотикийн болон пестицидийн үлдэгдэл, меламины бохирдол УМЭАЦТЛ-д 451 хандалтаар нийт 802 дээжид, нийслэл болон аймгуудын лабораторид, 170 хандалтаар нийт 471 дээжид сорил шинжилгээг хийж гүйцэтгэв.

10. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл

МЭЕГ-ын даргын 2022 оны А/51 дүгээр тушаалаар “Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөө”, “Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих удирдамж”-ийг тус тус батлуулж, ажиллалаа.

Уг арга хэмжээний үр дүнд 2022 онд улсын хэмжээнд 30.2 сая метр квадрат талбайд орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 40.8 сая метр квадрат талбайд, үүнээс: гоц халдварт өвчний голомтын, сэжигтэй бүсэд 4.1 сая м/кв талбайд, урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг 36.7 сая м/кв талбайд (68895 ширхэг малын хашаа хороо, саравч, 1246 ширхэг нийтийн эзэмшлийн талбай, 7421 ширхэг худаг уст цэг, 8737 ширхэг зоорь, агуулах, түүхий эд хадгалах цэг, худалдааны төв, хүнсний зах, нядалгааны цэг, тэжээлийн цэг, гахай, шувууны байр, өтөг бууц, устгалын цэг) объектыг хамруулан, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэсэн.

11. ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулах

ХХААХҮ-ийн 2022 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд улсын хэмжээнд том малын зүй бусын хорогдол 168.512 толгой мал хорогдсоноос 150.128 мянган толгой малын хүүр, сэг зэмийг устгалд оруулсан. Устгалын ажил 96%-ийн гүйцэтгэлтэй.

2022 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 15.5 сая м² талбайд 12.422 мянган ширхэг малын хашаа, хороо, саравч, 10.0 тонн өтөг бууц, 2126 ширхэг худаг уст цэг, 2795 ширхэг нийтийн эзэмшлийн талбай, 1729 ширхэг түүхий эд, бэлтгэх цэг, агуулах, хүнсний зах, худалдааны төв зэрэг объектыг хамруулан орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг хийсэн байна.

Энэ арга хэмжээнд 11263 хүн оролцсоноос 1007 нь удирдах албан тушаалтан, 848 нь малын эмч, 1542 нь туслах ажилтан байсан бөгөөд малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдийн 7866 төлөөллийг дайчлан оролцуулж, 1525 орчим тээврийн хэрэгсэл ашиглалаа. Уг арга хэмжээнд аймаг, орон нутгаас 374.3 орчим сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

12. Мал эмнэлэг, ариун цэвэр, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн сарын аян

УОК-ын 2022 оны 02 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангуулах, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний халдварын тархалтыг зогсоох, эрсдэлийг бууруулах зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах, малын хашаа хороог цэвэрлэж, халдваргүйтгэл хийх "Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн сарын аян"-ыг 2022 оны 4 дүгээр сарын 15-наас эхлэн улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнан ажиллалаа.

Сарын аяны хүрээнд улсын хэмжээнд 13.2 сая метр квадрат талбайд (9.9 мянган ширхэг малын хашаа хороо, саравч, 7.5 тонн өтөг бууц, 1851 ширхэг худаг уст цэг, 2244 ширхэг нийтийн эзэмшлийн талбай, 1713 ширхэг түүхий эд бэлтгэх цэг, худалдааны төв, хүнсний зах, махны үйлдвэр, зоорь агуулах) объектыг хамруулан орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг зохих заавар, стандарт зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн.

Уг сарын аяны арга хэмжээнд 5005 мянган хүн хүч (аймаг, сумын ЗДТГ, онцгой комисс, мэргэжлийн хяналтын газар, байгаль орчны улсын байцаагч, малын эмч, туслах ажилтан, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд) оролцож, 620 орчим тээврийн хэрэгслийг дайчлан ажилласан.

Нийтийн эзэмшлийн 1246 газрын гудамж талбай, шалган нэвтрүүлэх товчоо, тэдгээрийн ойролцоох 2.0 сая мкв талбайд халдваргүйжүүлэлт хийв.

13. Халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх

МЭЕГ-аас 2022 онд ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхэд зориулж АНМЭГ-т 4 дүгээр сарын төсвийн хуваарьт санхүүжилтийг (453 сая 114.9 мянган төгрөг) хуваарилсан.

Оны эцсийн байдлаар АНМЭГ-т халдвар хамгааллын нэг удаагийн хувцас 7166 ширхэг, олон удаагийн хувцас 701 ширхэг, халдваргүйтгэлийн бодис, бэлдмэл нийтдээ 11.6 тонн (4.1 тонн хлорын шохой, 3.0 тонн хай коф, 3.3 тонн суперкилл, 73 кг екоцид, 494 кг роксидид, 580 кг ханкон), багаж хэрэгсэл (22 ширхэг шүршигч аппарат, 466 ширхэг, 112 ширхэг автомакс мананцаржуулагч) тус тус нөөцтэй байна.

МЭЕГ-ын даргын А/239 тушаалаар баталсан ажлын хэсэг нь халдваргүйтгэлийн бодис 562 кг, халдвар хамгааллын нэг удаагийн хувцас 1000 ширхэг иж бүрдэл, халдваргүйтгэлийн багаж 15 ширхэг мананцаржуулагчийг тус тус худалдан авч, нөөцийг бүрдүүлсэн.

14. Шимэгчтэх болон халдваргүй өвчинтэй тэмцэх арга хэмжээ

Улсын хэмжээнд 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн МЭТ нь тухайн орон нутгийн өвчний гаралт, тархалтын судалгаанд үндэслэн, шимэгчтэх өвчний төлөвлөгөөг гаргаж, сум, дүүргийн ИТХ-аар батлуулсан шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөтэй нэгтгэн, МЭЕГ-ын даргын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/38 тушаалаар шимэгчтэх өвчний арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийг батлуулсан.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2022 онд 84.5 сая мал, амьтан хамрагдах төлөвлөгөөтэйгөөс 74.2 сая мал, амьтан хамрагдаж, шимэгчтэх өвчнөөс эмчлэн 87.9%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Мал угаалгад 35.4, туулгалтад 21.8, боловсруултад 14.4, үхрийн арьсны гуурын боловсруулалтад 2.6 сая толгой мал хамруулж, тус бүр 85.6%, 91.1%, 87.6%, 87.6%-ийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлэв.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг 99.2%, угаалга, туулга, боловсруултад хамрагдсан малын гүйцэтгэлийг 98.2%-аар тус тус МЭНС-д оруулсан байна.

“Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах журам”-ын 1, 3, 5 дугаар хавсралтаар шимэгчтэх, халдваргүй өвчин, шимэгчтэх өвчний арга хэмжээний жилийн эцсийн мэдээгээр 37 нэр төрлийн шимэгчтэх өвчнөөр 194.0 мянган толгой мал амьтан өвчилж, 0.286 мянган мал хорогдож, 193.7 мянган толгой мал эдгэрсэн байна.

Архангай, Увс, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Дорнод аймгууд шимэгчтэх өвчний халдварлалт өндөр байна. Уг өвчнөөр халдварласан малын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 2.2 дахин буурсан байна.

15. Зэрлэг амьтны өвчнийг тандалт сэдэвт олон улсын зөвлөгөөн

ДМАЭМБ-тай хамтран “Зэрлэг амьтдын өвчний тандалт” сэдэвт Олон улсын зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд Монгол орны зэрлэг амьтдын эрүүл мэндийн нөхцөл байдлыг тодорхойлох, өвчнөөс шалтгаалах үхэл, хорогдлыг тандан илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд талуудын оролцоог сайжруулах зорилгоор зохион байгуулав. Уг зөвлөгөөнөөр “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын хүрээнд зэрлэг амьтдын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбар хоорондын уялдаа холбоог сайжруулахад анхаарах асуудлуудыг хэлэлцэж, цаашид зэрлэг амьтны элдэв өвчнийг тандан илрүүлэх тандалтын тогтолцоог бий болгох, нэн шаардлагатай хийгдэх ажлуудыг тодорхойлов.

Зөвлөгөөнд ДМАЭМБ-ын Ази номхон далайн бүсийн төлөөлөгчийн газар, Зэрлэг амьтан хамгаалах олон улсын зөвлөл, Дэлхийн банкны МААЭЗЭН төсөл, БОАЖЯ, ЗӨСҮТ, МЭХ, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, АНМЭГ бусад төрийн бус байгууллагын төлөөлөл 60 гаруй албан хаагч оролцов.

16. ДМАЭМБ-ын Монгол улсын мал эмнэлгийн үйлчилгээний гүйцэтгэлийн явцын үнэлгээ

ДМАЭМБ-ын үнэлгээний баг 2019 оны 9-10 дугаар сард Монгол Улсад ажиллаж, МЭЕГ болон түүний харьяа лаборатори, газартай хамтран, мал эмнэлгийн салбарын гүйцэтгэлийн үнэлгээ, БММӨ өвчний хяналт, арга хэмжээнд үнэлэлт, дүгнэлт хийж, 4 бүлэг 56 заалт бүхий зөвлөмж өгсөн билээ.

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийн явцын үнэлгээг хийх зорилгоор ДМАЭМБ-ын баг 2022 оны 10 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж, 2019 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг үнэлгээ хийн, мал эмнэлгийн үйлчилгээний давуу болон сул талыг тодорхойлж, мал эмнэлгийн салбарын гүйцэтгэлийг үнэлэв.

МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг удирдлага, зохион байгуулалтаар хангах

- Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
- МХЕГ, МЭЕГ-ын хамтарсан мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээг үндэслэн, мал эмнэлгийн улсын байцаагчийн эрх шинээр хүссэн 36, эрх сунгуулах 233, эрх цуцлах 19 албан хаагчийн материалыг МХЕГ-т хүргүүлж шийдвэрлэн, мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг тавин ажиллаж байна.
 - "Зөрчлийн тухай хууль, ЗШША-ны тухай хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх, хэрэг бүртгэлт хийх" талаар танхимын сургалт хийснээр мал эмнэлгийн улсын /ахлах/ байцаагч нарыг 100% хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн байна.
 - Мал эмнэлгийн улсын /ахлах/ байцаагч нар хяналт шалгалт хийж, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд нөхөн төлбөр тооцон, шийтгэлийн хуудсанд ерөнхий индекс дугаар олгож, 287 зөрчил шийдвэрлэж, 33,400.000 төгрөг төвлөрүүлсэн байна.

2. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх

- MNS 5368-2018 “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа” стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр МЭҮН-ийн стандартын үзлэгийн асуумжийн дагуу 1012 нэгжийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн.
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтад Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 хэсэгт заасны дагуу сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн байцаагч нар яаралтай болон төлөвлөгөөт арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэн ажиллалаа (Зураг №16).



Зураг 16 . Дундговь аймагт хэрэгжүүлж буй дархлаажуулалтын гүйцэтгэл, хорио цээрийн арга хэмжээний хяналт хийх үеэр

- Шүлхий, БММӨ, хонь ямааны цэцэг, ҮАТӨ-ий дархлаажуулалтын гүйцэтгэлийг МЭНС-тэй тулгалт хийж хянан, гүйцэтгэл, баталгаажуулалтын хувийг гаргав. Гоц халдварт 4 төрлийн

- өвчний дархлаажуулалтын гүйцэтгэл улсын хэмжээнд 97.2% буюу товлосон хугацаанд хийж хэрэгжүүлж байгаа боловч МЭНС-ийн гүйцэтгэл 94%, баталгаажуулалт 91% байна.
- Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад хамрагдсан давхардсан тоогоор 327025 малчин өрхийн 13.3 сая толгой мал хамрагдаж, дархлаажуулалтын гүйцэтгэлийг 100% МЭНС-д оруулан, гүйцэтгэлийн баталгаажуулалт 99% биелсэн байна.
 - Гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, халдварын тархалтыг сүргийн түвшинд бууруулахаар үхэр, гахай, цаа бугыг дархлаажуулах улсын хэмжээний 2 удаагийн нэгдсэн арга хэмжээний үед гүйцэтгэлийн хяналтын үр дүнг сайжруулах зорилгоор зохих заавар, технологийн дагуу хийгдэж буй эсэх талаар тухайн газар дээр нь очиж хянах, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийт аймгийн хэмжээнд 312 сумын тасгийн улсын байцаагч, 120 ажлын хэсэг 43580 малчин өрхөд буюу нийт гүйцэтгэлийн 40.3%-д тухайн газар дээр нь очиж, дархлаажуулалтын явцын хяналтыг хийсэн байна (Зураг 17).
 - Дархлаажуулалтын гүйцэтгэлийг улсын хэмжээнд товлосон хугацаанд бүрэн хийж хэрэгжүүлсэн боловч МЭНС-ийн гүйцэтгэлийг тухайн цэг дээрээс оруулах, стандарт ажиллагааны заавар, технологи, САЗ-ын мөрдөлт болон вакцины хүйтэн хэлхээ хангах талаар зөрчил илэрснийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч шийдвэрлэсэн.



Зураг 17. Орон нутагт хэрэгжүүлж буй төлөвлөгөөт арга хэмжээний хяналт хийх үеэр

- Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан давхардсан тоогоор 5453 малчин өрхийн 2.6 сая толгой мал хамрагдаж, дархлаажуулалтын гүйцэтгэл 98% МЭНС-д бүртгэгдэж, гүйцэтгэлийн баталгаажуулалт 97% биелсэн байна.
- БММӨ-өөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан давхардсан тоогоор 11478 малчин өрхийн 3.0 сая толгой мал хамрагдаж, дархлаажуулалтын гүйцэтгэл 100% МЭНС-д бүртгэгдэж, гүйцэтгэлийн баталгаажуулалт 98% биелсэн байна.
- ҮАТӨ-өөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 19023 малчин өрхийн 1.1 сая толгой мал хамрагдаж, дархлаажуулалтын гүйцэтгэл 100% МЭНС-д бүртгэгдэж, гүйцэтгэлийн баталгаажуулалт 96% биелсэн байна.

3. Махны үйлдвэрийн хяналт, цахим систем нэвтрүүлэх

- Махны үйлдвэрийн үйл ажиллагааны цахим системийг улсын хэмжээнд мал төхөөрөх үйлдвэр, цехүүдэд бүрэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, үйлдвэрийн дэргэдэх болон гэрээт МЭҮН-ийн судалгааг нэгтгэн боловсруулж, мал төхөөрөх үйлдвэр 80, төхөөрөх цех 95, нийт 175 аж ахуйн нэгж, байгууллагыг мал эмнэлгийн нэгдсэн систем-<https://mahis.gov.mn/>, махны үйлдвэрийн үйл ажиллагааны систем-<https://mfos.mn/>-д бүртгэж, малын эмч, технологич, удирдах албан тушаалтны нэгдсэн бүртгэлийг бий болгож ажиллалаа.
- Мал, амьтан төхөөрөх, мах боловсруулах үйл ажиллагааг малын эмчийн хяналтад гүйцэтгүүлэх зорилгоор аймаг, нийслэлд мал төхөөрөх үйл ажиллагаа эрхэлж буй 164 аж ахуйн нэгж, байгууллагын хүнсний зориулалтаар бэлтгэсэн 836.834 толгой малыг малын эмчийн хяналтад хүлээн авч, 691.735 толгой малд төхөөрөхийн өмнөх, 691.735 толгой, дотор эрхтэн, гулуузанд төхөөрсний дараах мал эмнэлэг-ариун цэврийн үзлэг, магадлан шинжилгээг тогтсон горим, дарааллын дагуу хийж, мах, дайвар бүтээгдэхүүнийг үнэлэх, нийтийн хүнсний хэрэгцээнд тохиромжтой, аюулгүй мах бэлтгэх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэн ажиллалаа. Улсын хэмжээнд төхөөрөхийн өмнөх үзлэгт 25.060 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээгээр 29.918 адуу, 39.947 үхэр, 433.696 хонь, 188.493 ямаа, 2.345 тэмээ, нийт 691.735 толгой мал хамрагдаж, тухай бүр үзлэгийн дүнг махны үйлдвэрийн үйл ажиллагааны системд оруулан, хяналт тавин ажилласан.

4. Малын эмийн хяналт, захиргааны хэм хэмжээний сургалт

- МЭЕГ, МААЭЗЭН, ДЗМОУБ-аас хамтран "Улсын хэмжээнд эрт илрүүлэх, хариу арга хэмжээ болон оролцоот эпидемиологийн тандалтыг нэвтрүүлэх үндэсний түвшний сургалт"-ыг Булган, Хөвсгөл, Завхан, Увс аймагт зохион байгуулж, нийт 879 мал эмнэлгийн мэргэжилтнийг хамруулав.
- "Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр, цехийн өдөр тутмын үйл ажиллагаа, мал эмнэлгийн нэгдсэн систем, махны үйлдвэрийн үйл ажиллагааны системүүдийн хэрэгжилтэд хяналт тавих удирдамж"-ийн хүрээнд АНМЭГ-ын 65 улсын байцаагчдад цахим сургалт зохион байгуулан үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- МЭЕГ-ын даргын баталсан "Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцины зарцуулалтад дотоод хяналтыг сайжруулах зорилгоор тэмдэглэгээ хийх, хяналт тавих" удирдамжийн хүрээнд АНМЭГ-ын 89 албан тушаалтан, мэргэжилтэнд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинд тэмдэглэгээ хэрхэн хийх, бүртгэл хөтлөлт, хяналт тавих, вакцины савны устгалын ажлыг зохион байгуулах талаар цахим сургалт 5 удаа зохион байгуулав.
- Сэлэнгэ, Дархан-Уул, Завхан, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад аймаг, сумын МЭТ-ийн улсын байцаагч 2000 орчим мэргэжилтэнд мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналт, цаг үеийн мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа.

5. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах

МЭҮН-ийн эмч нар МЭНС-ээр мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүнд бичсэн 373.917 мал эмнэлгийн гэрчилгээг хянан баталгаажуулсан ба бичиг баримтын бүрдэл дутуу, хориглосон, хязгаарласан бүсээс 3.989 гэрчилгээ батлахаас татгалзаж, 29.460 мал эмнэлгийн гэрчилгээ бүхий мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн улсын байцаагч нар хяналт, шалгалт хэрэгжүүлсэн.

МААЭЗЭН төслийн санхүүжилтээр мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Төв аймгийн Лүн, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Архангай аймгийн Цахир сум, Багануур дүүргийн Хэрлэнгийн гүүр, Сонгинохайрхан дүүргийн Эмээлтийн Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгт компьютер, принтер, хяналтын камер, дрон, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэв.

Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгээр 2022 оны 1 дүгээр сард 1.930, 2 дугаар сард 990, 3 дугаар сард 950, 4 дүгээр сард 1.205, 5 дугаар сард 2.513, 6 дугаар сард 2.601, 7 дугаар сард 2.534, 8 дугаар сард 3.011, 9 дүгээр сард 2.573, 10 дугаар сард 3.214, 11 дүгээр сард 5.728, 12 дугаар сарын 12-ны байдлаар 2.144 мал эмнэлгийн гэрчилгээ бүхий мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүнийг МЭХЦХЦ-ийн мал эмнэлгийн улсын байцаагч нар шалган нэвтрүүлж, МЭНС-д шалгасан төлөвт оруулсан байна.

Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналт отор нүүдэл, шилжилт хөдөлгөөний зорилгоор хийгдэж буй малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг МЭЕГ-ын даргын баталсан 01 тоот удирдамжаар АНМЭГ-т хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

6. Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх

Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/193 тоот тушаалаар батлуулан, Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

7. МЭНС-ээр олгогдсон цахим гэрчилгээнд хяналт баталгаажуулалт хийх

- МЭНС-ээр олгогдсон мал эмнэлгийн цахим гэрчилгээний баталгаажуулалтын 103 удаагийн хүсэлтийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн, тайлант хугацаанд 5.800 мал эмнэлгийн гэрчилгээг баталгаажуулав.
- Хүнсний зориулалтаар төхөөрөгдөх нийтийн хэрэгцээнд зориулсан амьд малд 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 112.273 мал эмнэлгийн гэрчилгээгээр 58.878 адуу, 83.904 үхэр, 1.028.645 хонь, 443.637 ямаа, 4.415 тэмээ буюу нийт 1.619.481 толгой малд мал, амьтны эрүүл мэнд, 179.053 мал эмнэлгийн гэрчилгээгээр 101.340 мянган тонн мах, 12.049 гэрчилгээгээр 18.784 мян.тонн үнээний түүхий сүү, 548 гэрчилгээгээр 34.120 мянган өндгөнд хүнсний зориулалтын түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, гарал

үүслийн баталгаажуулалт хийж, мөшгөх тогтолцоог бүрдүүлэн, хүнсний аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэн ажилласан.

8. Лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний олголтод хяналт хэрэгжүүлэх

Мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээ (МШЦГ)-г улсын хэмжээнд 70 гаруй хүнсний зах, худалдааны төвд нэвтрүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 41.284 магадлан шинжилгээний гэрчилгээг МЭНС-ээр олгож ажилласан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 25 хүнсний зах худалдааны төвийн дэргэдэх мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээний 21 лаборатори ажиллаж байгаа бөгөөд эдгээр лаборатори нь нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд худалдаалагдахаар 26.008 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээтэй нийлүүлэгдсэн мал, амьтны гаралтай хүнсний зориулалттай түүхий бүтээгдэхүүнд 22.949 ширхэг МШЦГ-г олгосон байна.

Улсын хэмжээнд анх удаа нөөцийн махны нийлүүлэлтийн үеийн махны чанар, аюулгүй байдлын баталгааг мал эмнэлгийн байгууллага гаргаж ажилласан ба худалдаанд гарсан 5123.5 тонн маханд 8986 МШЦГ-г олгон, нийт бэлтгэгдсэн махны 40.1%-ийг мал эмнэлгийн байгууллагын хяналтад худалдаанд нийлүүлэх ажлыг зохион байгуулав.

9. Нөөцийн махны чанар, аюулгүй байдлын хяналт

Нийслэлийн хүн амын 2021-2022 оны хаврын улирлын нөөцийн махны бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулан, 9 дүүргийн 565 дэлгүүрт мал эмнэлгийн 28 улсын байцаагч хяналт тавин ажиллав. Нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч 23 аж ахуй нэгжийн бэлтгэсэн махыг МЭНС, махны үйлдвэрийн үйл ажиллагааны системээр хяналт хэрэгжүүлэн мал эмнэлгийн байгууллагын хяналтад лабораторийн МШЦГ-г нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн.

Нөөцөд бэлтгэгдсэн 3.832 тонн үхэр, 7.664 тонн хонь, 1.277 тонн ямааны махнаас төлөөлүүлэн авсан 67 сорьц, дээжид шүлхий өвчний үүсгэгч болон антибиотикийн үлдэгдэл, хүнсний хордлого үүсгэгч нян илрээгүй байна. Хяналт шалгалтын танилцуулгыг 2022 оны 01/615 тоот албан бичгээр ХХААХҮЯ-нд хүргүүлж ажилласан.

10. Малын эмийн чанар, аюулгүй байдал, хэрэглээнд тавих хяналт

- Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины савны устгал. УОК-ын 2022 оны 02 тоот тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр албан даалгавар, МЭЕГ-ын даргын 2022 оны А/77 дугаар тушаалын дагуу ОХУ-д үйлдвэрлэсэн малын гоц халдвар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 050222, 020122 серийн дугаартай вакцин татан авч, МЭЕГ-ын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцины зарцуулалтад дотоод хяналтыг сайжруулах зорилгоор тэмдэглэгээ хийх, хяналт тавих” удирдамжийн дагуу аймаг, нийслэл 330 сум дүүрэг дэх 1.002 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хуваарийн дагуу кодлон олгосон.

Улсын хэмжээнд нийт 2.067 хайрцаг буюу 51.945 ширхэг сав вакцин зарцуулахаар тараагдсанаас 1.964 хайрцаг 49.315 ширхэг шүлхийн вакцины савыг буцаан татан устгаж, аймаг бүр улсын байцаагчийн устгалын акт үйлдэж, ажлын явцыг гэрэл зургаар баримтжуулан, тайланд хавсарган ирүүлээд байна. Үлдэгдэл 105 хайрцаг, 2630 сав вакцин нь аймгийн МЭГ-ын вакцин хадгалах хөргүүрт /хүйтэн хэлхээ/ аюулгүй хадглагдаж байна.

11. Мал эмнэлгийн салбарын сургалт, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмын хэрэгжилт

-Төгсөлтийн дараах сургалт

Мал эмнэлгийн салбарын сургалт хөгжлийн 2022 оны 5 багц 50 сургалтын төлөвлөгөөний дагуу 3.450 гаруй эмч мэргэжилтнийг хамруулсан байна. Үүнээс гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан уулзалт сургалтад 300, төслийн болон хамтран ажилладаг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлэгт 1.050, дотоодын болон хамтрагч байгууллагуудтай хамтран цахим сургалтад давхардсан тоогоор 2.100, төрийн албаны мэргэшүүлэх богино хугацааны 4 төрлийн сургалтад МЭЭГ-аас 16 албан хаагчийг тус тус хамруулсан байна.

- Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох

МЭЭГ-ын даргын 2022 оны “Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох тухай” А/118 тоот тушаалаар 15 эмчид мэргэшлийн ахлах, тэргүүлэх зэрэг олгуулан шийдвэрлүүлсэн. Мэргэшлийн зөвлөх зэргийг шинээр олгох, сунгуулах хүсэлт ирүүлсэн 18 эмч мэргэжилтний материалыг сургалтын комиссоор хэлэлцүүлэн, ХХААХҮ-ийн сайдад албан бичиг, тушаалын төсөл, холбогдох материалын хамт уламжилсан.

- Сургалтын комиссын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Сургалтын комисс 2022 онд нийт 8 удаагийн хуралдаанаар 20 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлүүлэв.

- Мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил, удирдлагын систем (МЭХНХУС)

Мал эмнэлгийн салбарын ажиллах хүний нөөц, тэдний сургалт хөгжил, харилцаа холбоо, ажил эрхлэлтийг зохион байгуулах зорилготой системийг МААЭЗЭН төслийн дэмжлэгээр хэрэглээнд нэвтрүүлж эхэллээ.

Хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд малын эмч мэргэжилтний бүртгэлийн мэдээлэл, итгэмжлэлийн мэдээлэлийг системтэйгээр оруулж эхлээд байна.

-Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт

ХХААХҮ-ийн сайдын тушаалаар баталсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт” явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сургалт хийх байгууллага, багийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулан, нээлттэй сонгон шалгаруулан төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтын 10 хөтөлбөр, итгэмжлэлийн сургалтыг зохион байгуулах байгууллагыг сонгон шалгаруулав.

12. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажуулалт

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасний дагуу аймаг, нийслэлийн МЭГ-т шинээр МЭҮН байгуулсан 38 аж ахуйн нэгжийн мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хийлгэх хүсэлтийг шийдвэрлэв.

13. Мал, амьтан болон тэдгээрийн гаралтай олон улсын мал эмнэлгийн экспорт, импортын гэрчилгээ олгох

Мал эмнэлгийн байгууллага нь 75 нэр төрлийн мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд баталгаа гарган ажиллаж байна. Тухайлбал: 2022 онд 10.997 мянган тонн адууны мах, 745 мянган тонн үхрийн мах, 9.026 мянган тонн хонины мах, 12.349 мянган тонн ямааны махыг экспортод гаргасан байна.

Монгол Улс ДМАЭМБ-т элссэн 182 орноос 2022 оны байдлаар 43 оронтой гэрээ хэлэлцээр хийж, импортлох үеийн шаардлага тохиролцоод байна.

Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний олон улсын экспортын мал эмнэлгийн гэрчилгээг давхардсан тоогоор нийт 1.267 аж ахуйн нэгжид 1.492, үүнээс 315 гэрчилгээ нь мал, амьтан буюу нохой, муур, адуу, хонь, ямаа, идлэг шонхор, ятуу шувууг Монгол Улсаас гадаад улс руу экспортлоход олгогдсон байна. Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний 1.177 гэрчилгээг мах, малын дайвар бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуурт олгожээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд 490.553 тонн мах, 2.596.797 ширхэг арьс шир, 10.274.226 тонн ноос, ноолуур гадаад зах зээлд гарсан байна.

Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний олон улсын импортын мал эмнэлгийн 610 гэрчилгээг давхардсан тоогоор нийт 596 аж ахуйн нэгжид олгоод байна. Гадаад орноос тахиа, гахайн мах, хүнсний өндөг импортлоход Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлыг хангах тухай хууль, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу Монгол улсаас эрсдэлийн үнэлгээ хийсэн (БНХАУ-ын 36, ОХУ-ын 38, БНПУ-ын 7, БНЭУ-4, ХБНБеларусь улсын-2).

Олон улсын чанар стандартыг хангасан 87 үйлдвэртэй шууд гэрээлсэн аж ахуйн нэгжид олон улсын гэрчилгээг олгосон байна. Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй аж ахуйн нэгжээс татан авалт хийдэг байсан 112 аж ахуйн нэгжид эрх зүйн үндэс, хууль дүрмийн талаар тайлбарлан сануулж, одоогийн байдлаар 38 аж ахуйн нэгж баталгаатай барааг тогтмол оруулж ирж байна.

14. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад улс орны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хүсэлтийг шийдвэрлэх ажлын хүрээнд

ОХУ, Беларусь улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хүсэлтийг 2022 онд 127 аж ахуй нэгжид ОХУ-ын улсын ургамал, хорио цээр, хяналтын алба болон Беларусь улсын Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн орлогч сайд, мал эмнэлэг, хүнсний үйлдвэрлэлийн хяналтын газарт, ОХУ, Беларусь улсад суугаа элчин сайдын яам, гадаад харилцааны яаманд уламжлан ажилласан байна.

15. Малын шимэгчтэх өвчинтэй тэмцэх төлөвлөгөөт арга хэмжээнд хяналт тавих, үр дүнг үнэлэх

МЭҮН-үүдээр мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн эмчлэн сэргийлэх угаалга, туулга, боловсруулалтын гүйцэтгэлийг өрх тус бүрээр МЭНС-д мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулж, улсын хэмжээнд давхардсан тоогоор 577.564 малчин өрхийн 74.7 сая толгой малыг хамруулж, төлөвлөгөөний гүйцэтгэл МЭНС-д 84.5 % байна. Сум, дүүрэг дэх МЭТ-ийн мал эмнэлгийн улсын байцаагч нар хяналтын нэгдсэн удирдамжид заасны дагуу угаалга,

туулгалт, боловсруулалтын явцад улсын хэмжээнд 35%-д нь газар дээр нь хяналт хэрэгжүүлж, шимэгчтэх өвчний эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээнд товлосон хугацаанд хэрэгжүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

16. Мал, амьтны өвчингүй тайван байдлыг баталгаажуулах, халдварт өвчнийг эрт илрүүлэх арга хэмжээнд хяналт тавих, эрсдэлийг үнэлэх

"Улсын хэмжээнд эрт илрүүлэх, хариу арга хэмжээ болон оролцоот эпидемиологийн тандалтыг нэвтрүүлэх үндэсний түвшний сургалт"-ыг Өвөрхангай, Дундговь, Төв, Хэнтий, Дорнод, Дорноговь аймагт зохион байгуулж, мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын улсын байцаагчид болон МЭҮН-ийн малын эмч нарын бүрэлдэхүүнтэй нийт 750 мал эмнэлгийн мэргэжилтнийг хамруулав.

17. Импортын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлийн задлан шинжилгээ

Монгол улс дахь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ)-ын элчин сайдын яам болон "Таван богд фүүдс" ХХК-аас ирүүлсэн хүсэлт, МЭЕГ-ын даргын 2022 А/102 тоот тушаалаар мал эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоёр улсын хоорондох мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдааны чөлөөт байдлыг хангуулах зорилгоор ИБУИНХУ-д Гаалийн Ерөнхий газар, Монгол улс дахь Английн элчин сайдын яамны төлөөлөлтэй хамтран ажиллалаа.

Энэ ажлын үр дүнд Англи улсаас Монгол улсад тахианы мах, загас далайн гаралтай бүтээгдэхүүн, үхрийн үр импортлох нөхцөлийн талаар хэлэлцэж, 2 талд урьдчилан хүргүүлсэн саналуудыг бататган, гэрчилгээний загвар, худалдааны ерөнхий зарчмыг тохиролцов.

ТАРХВАР ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Өвчний мэдээ, тайлан

Мал, амьтны гоц халдварт шүлхий, YATӨ, БММӨ, хонины цэцэг өвчний өдөр тутмын болон МЭНС-ийн мэдээллээс малын шилжилт хөдөлгөөний мэдээг нэгтгэн боловсруулж, дашбоард, PowerPoint хэлбэрээр бэлтгэж, ХХААХҮЯ, МЭЕГ, УОК, НША, мал эмнэлгийн газруудад өдөр тутам хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллалаа.

Халдварт, архаг халдварт өвчин: 2022 онд улсын хэмжээнд 174 сум, дүүрэгт, 21 нэрийн халдварт өвчин (давхардсан тоогоор) бүртгэгдсэн болно.

Нийт 365 сумын 174 буюу 47.6 хувьд нь мал, амьтны халдварт, архаг, зооноз халдварт өвчний тохиолдол илэрсэн байна. Адууны нийлүүлэг, адууны томуу, боом, дотрын халдварт хордлого, листериоз, маеди-висна, ринопневмони, цахлай өвчний гаралт 2022 онд өссөн үзүүлэлтэй байна. 2022 онд халдварт өвчний гаралт Архангай, Булган, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өмнөговь, Увс, Ховд, Хэнтий аймагт өссөн байна.

Монгол улсад 2022 онд бүртгэгдсэн халдварт өвчнүүдээс 6 нь улсын төсвийн, 7 нь орон нутгийн төсөв, 2 нь иргэн, хуулийн этгээдийн санхүүжилтээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд 6 нь урьдчилан сэргийлэх өвөрмөц хариу арга хэмжээгүй өвчин байв.

Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгийн 8 сумд боом өвчний 14 тохиолдол, Баянхонгор, Булган, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгийн 8 сумд листериоз өвчний 90 тохиолдол тус тус бүртгэгдэж, тохиолдлын тоо өмнөх оноос өссөн бол Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Увс аймгийн 16 сумд бруцеллэз өвчний 87 тохиолдол, Улаанбаатар хотын 1 дүүрэгт ям өвчний 2 тохиолдол, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 44 сумд галзуу өвчний 94 тохиолдол тус тус бүртгэгдэж, тохиолдлын тоо буурсан байна.

2. Лабораторийн тандалт, шинжилгээ

- Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний бэлэн байдал:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2022 онд худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэх “Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, хэрэглэгдэхүүн, шил сав худалдан авах ХХААХҮЯ/202202137 дугаартай тендер”-ийн гэрээгээр 3 багц нийт 815.795.980 төгрөгийн өртөг бүхий 307 нэр төрлийн оношлуур хэрэглэгдэхүүнийг УМЭАЦТЛ болон АНМЭГ-ын лабораторид олгосон.

2. Улсын хэмжээнд 2022 онд худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэх "Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж худалдан авах" ХХААХҮЯ/202201098 дугаартай тендерийн 6 нэр төрлийн 62 ширхэг бараа, "Гоц халдварт БММӨ, YATӨ-ий оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлэгчийг сонгох" ХХААХҮЯ/202201100 дугаартай тендерийн 13 нэр төрлийн 88 ширхэг бараа, бруцеллэз өвчний эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл худалдан авах тендерийн 8 нэр төрлийн 1960 ширхэг 502.861.280 төгрөгийн өртөг

бүхий 29 нэр төрлийн барааг хуваарьт хугацаанд нь УМЭАЦТЛ болон аймаг, НМЭГ-ийн лабораторид нийлүүлсэн.

- Малын гоц халдварт, халдварт өвчний тандалт, төлөвлөгөө, тайлан: Улсын хэмжээнд хэрэгжүүлэх мал эмнэлгийн тандалт шинжилгээний 2022 оны төлөвлөгөөг МЭЭГ-ын даргын 2022 оны А/80 дугаар тушаалаар батлуулан, мал эмнэлгийн лабораторийн сүлжээний хэмжээнд зохион байгууллаа. Үүнд:

Малын гоц халдварт 4 өвчин (шүлхий, хонины цэцэг, ББМӨ, ҮАТӨ)-ий халдварын тархалтыг тогтоох, халдварт өвчин, халдваргүйг баталгаажуулах (үхрийн сүрьеэ лейкоз, цээж, ямааны годрон, хээлтүүлэгчийн бруцеллөз, гахай, адууны зарим өвчний тандалт), гоц халдварт болон халдварт өвчний дархлаажуулалтын дараах мониторинг, идэвхгүй тандалт гэсэн 4 чиглэлээр нийт 404.303 толгой мал сүргийг хамруулахаар төлөвлөснөөс 331.166 толгой малыг хамруулж, 81.9% -ийн гүйцэтгэлтэй хэрэгжлээ.

Монгол орны хэмжээнд малын гоц халдварт 4 нэрийн өвчин (шүлхий, ББМӨ, хонины цэцэг, ҮАТӨ)-ий халдварлалтын (тархалтын) түвшнийг хот айл (сүрэг)-ын хэмжээнд тодорхойлох (estimate of prevalence), тархалтын цар хүрээг лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн, хот айлын статусаар (халдвартай, халдваргүй) тодорхойлох үндсэн зорилгын хүрээнд 21 аймаг, нийслэлийн нийт 10.080 үхэр, богийн ийлдсийн сорьц цуглуулсан.

Тандалтын үр дүнгээр нийт 10.052 сорьцод шүлхий өвчний халдвар илрүүлэх шинжилгээг хийхэд 972 сорьц буюу 9.7%-д шүлхийн үүсгэгчийн бүтцийн бус уургийн эсрэг биом, ББМӨ-ий халдвар илрүүлэх шинжилгээг нийт 7.568 сорьцод хийхэд 266 сорьц буюу 3.5%-д нь уг өвчний вирусийн эсрэг биом тус тус илэрсэн байна. Хонины цэцэг өвчнөөр 7.558 сорьцоос 45 сорьц буюу 0.6% нь эерэг, ҮАТӨ-өөр 2.502 сорьцоос 9 буюу 0.3% нь тус тус эерэг дүнтэй байна.

Малын гоц халдварт өвчнөөс хамгаалах дархлаажуулалтын мониторингийн дүнгээр шүлхийн вирусийн О хэвшилд 93%, А хэвшилд 81%-тай хамгаалах дархлаа тогтсон, ББМӨ-ий эсрэг дархлаажуулалтаар нийт вакцин таригдсан сүргийн 73%, бруцеллөз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтаар нийт дархлаажуулсан сүргийн 81.4 хувьд тус тус хамгаалах дархлаа тогтсон байна.

Малын бруцеллөзтой тэмцэх стратегийн зорилтын хүрээнд бруцеллөзын тандалтыг сүүлийн таван жил дараалан (2018-2022) 17, 20 аймаг, нийслэлийн хээлтүүлэгч малыг хамруулан гүйцэтгэсэн. Нийт шинжилгээний дүнгээр 2018-2020 оны халдварлалтын хувь буурсан боловч 2021 онд 0.04%-аар өссөн бол 2022 онд 0.1% болж буурсан байна. Бруцеллөзын стратеги хэрэгжиж эхлэхээс өмнөх буюу бруцеллөзын халдварлалтын суурь түвшин 2011 онд 0.97% байсан бол 2022 онд 0.10% болж, 0.87%-аар буурсан байна.

Монгол улс үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалтаар 2021 онд 21 аймаг, нийслэлээс 2.500 үхрийн сорьц, 2022 онд 21 аймаг, нийслэлээс цуглуулсан 2.500 сорьц, саалийн фермийн 1.250, нийт 6.250 сорьцод хийсэн шинжилгээгээр бүгд сөрөг дүнтэй буюу өвчний халдвар илрээгүй.

2004-2022 онд Үхрийн тархи сархиатах өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалтыг Монгол орны зүүн, баруун, төв, говийн бүсийг төлөөлүүлэн Архангай, Булган, Дорноговь, Увс, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотыг тус тус хамруулан үхрийн тархины эдэд прион уураг илрүүлэх шинжилгээг гүйцэтгэсэн. 2004-2021 онд нийслэл болон Архангай, Булган, Увс, Ховд, Дорноговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгаас цуглуулсан 6.030 үхрийн тархины эдийн сорьцыг шинжлэхэд бүгд сөрөг (-) үр дүнтэй байв. 2022 онд Сэлэнгэ, Сүхбаатар, Булган аймгаас цуглуулсан 180 үхрийн тархины эдийн сорьцын шинжилгээгээр эмгэг төрүүлэгч прион уураг илрээгүй. Монгол улс нь үхрийн тархи сархиатах эмгэгээр эрсдэл багатай 2 хөрш (ОХУ, БНХАУ) орны дунд оршдог бөгөөд сүүлийн 17 жилийн турш явуулсан тандалт шинжилгээний ажлын үр дүнгээс үзэхэд Монгол улс уг өвчнөөр тайван, эрсдэлгүй болохыг харуулж байна.

- **Гахайд зонхилон тохиолдох халдварт өвчний болон гахайд хийгдсэн дархлаажуулалтыг тандах шинжилгээ:** Шүлхий өвчний вирусийн эсрэг бием нийт сорьцын 74%-д илэрсэн нь гахайн сүрэгт шүлхийн халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлэх хамгаалах дархлааны түвшин хангалттай түвшинд буйг илэрхийлж байна.

Гахайн парвовирусийн халдварыг илэрхийлэх вирусийн эсрэг бием нийт сорьцын 59%-д илэрсэн нь уг өвчний халдвараас үүдэлтэй эсрэгбиемийн нийлэгжил идэвхжиж байгааг илтгэх ба энэ нь цаашид өсвөр торойн хорогдол, гахайн ашиг шим, бүтээгдэхүүний гарцад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Лабораторийн шинжилгээнд үндэслэн гахайн үржил-амьсгалын зам хам шинж, ходоод гэдэсний үрэвсэл, гахайн африк мялзан, корона вирусын халдвар, томуу, микоплазмын халдвар, бруцеллөз өвчнөөр тандалтад хамрагдсан аймаг, нийслэлийн гахайн сүрэг тайван, эрсдэл багатай байна.

Төвийн бүсийн 5 аймаг, Улаанбаатар хотын гахайн аж ахуй, өрхийн гахайнаас санамсаргүй сонголтоор цуглуулсан 209 ийлдсийн гахайн сонгомол мялзан өвчний вирусийн эсрэгбием илрүүлэхэд 55 сорьц буюу 26%-д эсрэгбием илрэв. Энэ нь гахайн сонгомол мялзан өвчнөөс сэргийлэх вакцины хариу урвал, халдвараас хамгаалах дархлааны түвшнийг илэрхийлж байна.

- **Лабораторийн шинжээчдийн чадавхжуулах:** Мал эмнэлгийн сүлжээ лабораторийг хөгжүүлэх богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 онд Дэлхийн банкны МААЭЗЭН төсөлтэй хамтран, 3 багц сургалт (Мал эмнэлгийн лабораторийн чанар хангалтын тогтолцоо, Мал эмнэлгийн лабораторийн бизнес менежмент, Мал эмнэлгийн лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн эргэлзээг үнэлэх) зохион байгуулж, лабораторийн 159 ажилтныг хамруулав.


3. Мал эмнэлгийн тархвар зүйн судалгаа болон мал эмнэлгийн арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ

Дэгдэлтийн судалгаа: Нийт 3 аймгийн 8 сумын 21 малчин өрхөөс дэгдэлтийн судалгааны болон эдийн засгийн хохирлын асуумжийг тус тус авч, хэсэгчилсэн ярилцлага явуулах аргаар эрсдэлийн замыг тодорхойлон, дүн шинжилгээ хийж, холбогдох газруудад зөвлөмж чиглэл хүргэж ажилласан. БММӨ-ий хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр тухай бүрд нь ханган ажиллаж байв. Мөн судалгааны үр дүнгээр халдвар

бүртгэгдсэн эхний сумдын мал 8 дугаар сарын 10-ны өдрөөс өвчилсөн боловч 9 дүгээр сарын 1-ний өдөр, түүнээс хойш хорио цээрийн дэглэм тогтоосон байна. Лабораторийн шинжилгээгээр урьдчилсан оношийг баталгаажуулсны дараа хорио цээрийн дэглэм тогтоосноор малын өвчлөл буурч буй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дэгдэлтийн муруй: Дэгдэлтийн судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн малд өвчний шинж тэмдэг илэрсэн, мал үхсэн, малын эмчид мэдээлсэн цаг хугацааны дарааллаас үзэхэд өвчний шинж тэмдэг илрэх байдал нь тархвар зүйн 33-34 дэх долоо хоногт оргил үедээ хүрсэн нь халдвар хүрээгээ тэлснээс хойш илрүүлснийг нотолж байна (Зураг 18).


Зураг 18. Дэгдэлтийн судалгаанд хамруулсан 3 аймгийн 21 малчин өрх дэх дэгдэлтийн муруй, тохиолдлын тоогоор



МЭЕГ-ын даргын 2022 оны А/210 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2022 оны 09-10 дугаар сард Архангай аймгийн Жаргалант, Эрдэнэмандал, Хөвсгөл аймгийн Рашаант, Их уул, Булган аймгийн Баян-Агт, Хутаг-Өндөр, Сайхан, Бугат сумд гарсан БММӨ-ий дэгдэлтийн судалгаа хийх, голомтын хүрээг тогтоох, хорио цээрийн арга хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Булган аймгийн Хутаг-Өндөр, Жаргалант сумдад 2022 оны 7 дугаар сарын дундуур БММӨ-ий халдвар нэвтэрсэн байх магадлалтайг тогтоов.


Өвчлөл ба хорогдлын хувь: БММӨ оношлогдсон 3 аймгийн 7 сумын 23 малчин өрхийн нийт 34.674 толгой бог малын 8.5% буюу 2.532 толгой мал өвчилснөөс Булган аймагт хамгийн олон мал өвчилж (2020), хорогдсон (293) байна. Өвчилсөн малын эзлэх хувь Архангай 16.9%, Булган 8.0%, Хөвсгөл 10.3% аймагт оногдож байна. Хөвсгөл аймгийн Рашаант сум, Булган аймгийн Баян-Агт сумд өвчлөлийн түвшин илүү өндөр буй нь тус хоёр сумдын зааг нутагт халдвар эрчимтэй тархсаныг илтгэж байна (Зураг 19).



Зураг 19. Өвчлөл, хорогдлын хувь

БММӨ гарах (вирус голомтын бүсэд нэвтрэх) болон цаашид халдвар дамжин тархахад нөлөөлсөн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор малчид, мал эмнэлгийн анхан болон дунд шатны байгууллагуудад ажиллаж байгаа малын эмч нарт хандсан асуумж, үйл явдлын өрнөлийг хүүрнэн шалгах хуудасны дагуу амаар болон утсаар, зайнаас уулзалт ярилцлага хийн шаардлагатай мэдээллийг цуглуулсны дагуу БММӨ-ий вирус нэвтрэх, өртөх, тархах боломжит хүчин зүйлийг харгалзан, эрсдэлийн замуудыг ялган тодорхойлсон.

Архангай аймгийн Жаргалант, Хөвсгөл аймгийн Рашаант, Их-Уул, Булган аймгийн Баян-Агт, Хутаг-Өндөр, Бугат, Сайхан сумдад БММӨ тархахад нөлөөлсөн гол эрсдэлт хүчин зүйлсэд отор нүүдэл, шууд хавьтал, сүрэг сэлбэлт, хулгайн замаар дамжсан малын шилжилт хөдөлгөөн, амьд малын худалдаа хамаарч байна (Зураг 20).




Зураг 20. Эрсдэлт хүчин зүйл

Эмнэл зүйн шинж тэмдэгт суурилсан эрсдэлийн үнэлгээ:

1. БММӨ-ий эмнэл зүйн шинж тэмдэгт суурилсан асуумж судалгааг МЭГ, МЭТ-ын малын эмч нартай хамтран 2022 оны 5 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 8-ны хооронд аймаг, нийслэлийн 221 сум, дүүргээс 5.509 өрхөөс утсаар болон цахимаар авсан.

Судалгааны дүнгээс үзэхэд аймаг, нийслэлийн 221 сум, дүүргийн 5.509 малчин өрхөөс 1.027 (18.6%) өрхийн малд өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн байна.


БММӨ-ий эмнэл зүйн шинж тэмдгийг өрхийн түвшинд цаг хугацаагаар авч үзвэл 2 болон 4 дүгээр сард 15-23 өрхийн малд шинж тэмдэг илэрсэн байна. Шинж тэмдэг илэрсэн гэж хариулсан 64 (1.1%) малчин өрхийн хөрш айлуудад мөн ижил шинж тэмдэгтэйгээр мал өвчилсөн байна. Судалгаанд хамрагдсан 144 (2.6%) өрхийн 1701 хонь, 906 хурга, 1.146 ямаа, 1.118 ишиг, нийт 4.871 толгой мал хорогдсон талаар мэдээлсэн байна (Зураг 21).



Зураг 21. БММӨ-ий шинж тэмдэг

Нийт 1.027(18.6%) малчин өрхийн малд шинж тэмдэг илэрснээс 86 (8%) өрх малын эмчид дуудлага өгсөн байна. Дуудлагын дагуу 63 (6%) өрхөд малын эмч үзлэг шинжилгээ хийж, өвчтэй малыг тусгаарлан, халдваргүйтгэж, шинж тэмдэгт суурилсан эмчилгээ хийсэн байна.

Судалгаанд хамрагдсан 1.096 өрхөөс Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар баг, Баруун-Урт сумын 8 дугаар багийн 2 (0.2%) өрхийн малд 2022 оны 5 дугаар сарын 19-26-нд уг өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн байж болзошгүй үр дүн гарсан байна. ҮАТӨ-ий дархлаажуулалт хийж байх хугацаатай тухайн өрхийн малд уг өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн хугацаа давхцаж байгаа нь малын эмч нар тарилга хийхдээ үзлэг хийгээгүй эсвэл хангалтгүй хийснийг илтгэж байна (Зураг 22).




Зураг 22. Судалгаанд хамрагдсан өрхийн байршил

ҮАТӨ Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ аймагтай залгаа ОХУ-ын хилийн бүсэд бүртгэгдсэн эрсдэлд үндэслэн уг өвчний эмнэл зүйн шинж тэмдэгт суурилсан асуумж судалгааг Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн МЭГ, МЭТ-ын малын эмч нартай хамтран 2022 оны 6 дугаар сарын 21-26-ны өдрүүдэд 1.096 өрхийг хамруулан, утсаар болон цахимаар авсан.

Мал, амьтны өвчний улсын тархвар зүйн зураглал


Гоц халдварт өвчний дархлаажуулалт (шүлхий, БММӨ, ҮАТӨ, хонины цэцэг), өвчний гаралтын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, тархвар зүйн зураглал, тархалтын урьдчилсан таамаглалыг 7 хоног бүр гаргаж, удирдлага, мэргэжилтнүүдийг мэдээллээр хангасан.

Улсын хэмжээнд 2021-2022 онд гарсан шүлхий өвчний мэдээллээр 12, аймаг тус бүрээр шүлхий өвчний гаралт тархалтын 40 газар зүйн зураглал гаргаж мэдээллээр хангаж ажилласан (Зураг 23).



Зураг 23. Халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын зураглал

Улс (боом, галзуу, адууны томуу, листериоз, гахайн сонгомол мялзан, шувууны тахал, хонины цэцэг), орон нутгийн төсөв (дотрын халдварт хордлого, дуут хавдар, цусан халдвар, коли-иж балнад, иж балнад, гахайн цусан халдварт, гахайн ёлом, ДХХ-энтербактериоз), иргэн хуулийн этгээдээс санхүүждэг (сохор догол, шөвөг яр, сахуу), нийт 22 нэр төрлийн өвчний дархлаажуулалтын зураглал боловсруулсан (Зураг 24).



Зураг 24. Халдварт өвчний гаралтын зураглал

Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан мал, амьтны нийт 65 нэрийн өвчний тархвар зүйн зураглалыг шинэчлэн боловсруулав.


Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний дархлаажуулалт, гаралтыг харьцуулсан 22 зураглал гаргаж, өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

4. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээний тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Хаврын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээний тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний үр дүн:


1. Дархлаажуулалтын үеийн зардал /орон нутаг/ 1.301.0 сая төгрөг,
2. Шатахуун, туслах ажилтан, бусад зардал /орон нутаг/ 726.6 сая төгрөг,
3. Тээвэр, хадгалалтын зардал /орон нутаг/ 144.0 сая төгрөг,
4. Вакцины үнэ /улс/ 3.547.0 сая төгрөг,
5. Үйлчилгээний хөлс /улс/ 1.710.2 сая төгрөг,
6. Гааль/татвар /улс/ 549.7 сая төгрөг, нийт 7.978.8 сая төгрөгийг зарцуулснаас 2.171.7 (27.2%) сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5.807.0 (72.8%) сая төгрөгийг улсын төсвөөс гаргасан байна.

Нийт зардлын 99.5%-ийг үхэр, 0.47%-ийг гахай, 0.05%-ийг цаа буга тарихад зарцуулсан бөгөөд 1 үхэрт 2.225 төгрөг, 1 гахайд 2.063 төгрөг, 1 цаа бугад 1.640 төгрөг оногдож байна. Вакцины үнэ нь улсын төсвийн зардлын дийлэнх хувийг эзэлж байна (Зураг 25).




Зураг 25. Зардлын хэмжээ /харьцуулалт/

Мөн шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд зарцуулагдсан зардлын 3%-ийг аймгийн МЭГ, 16%-ийг ЗДТГ, 9%-ийг Онцгой комисс, 72%-ийг МЭЕГ-аас тус тус зарцуулсан байна (Зураг 26).



Зураг 27. Зардал ба хуваарьлалт


Галзуу өвчний тохиолдлын болон дархлаажуулалтын гүйцэтгэлийн сүүлийн 3 жилийн тоон мэдээнд хийсэн шинжилгээгээр Өвөрхангай, Дундговь, Булган, Говь-Алтай, Архангай аймгийн сумдад хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна (Зураг 28).



Зураг 28. Дархлаажуулалтын тоон үзүүлэлт

Төвийн бүсийн зарим аймаг, баруун урд болон урд бүсийн аймгуудад эрсдэл өндөр байна. Галзуу өвчний тохиолдлын 70-80% нь мал, 30-20% нь амьтан эзэлж байна. Зэрлэг амьтдыг дархлаажуулах замаар хүн, мал, амьтныг галзуу өвчний халдвар авахаас урьдчилан сэргийлэх, малд оношлогдож буй халдварыг бууруулах боломжийг судалж үзэх шаардлагатай байна.

Сүүлийн 20 жилд нийт 1.273 толгой мал, амьтан галзуу өвчнөөр өвчилснөөс 1.075 мал (84%), 198 амьтан (16%) тус тус эзэлж буй бөгөөд 2008 оноос өвчний тохиолдол нэмэгдэж, 2020 онд хамгийн их өвчлөл бүртгэгдсэн ч 2022 оны байдлаар өвчлөл буурчээ (Зураг 29).



Зураг 29. Галзуу өвчний тархвар зүйн муруй

5. АНМЭГ-ын мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцийн тоон мэдээлэл

1. Мал эмнэлгийн газрууд нь мал эмнэлгийн бэлэн байдлын төлөвлөгөөг батлуулсан боловч бэлэн байдалд зориулсан нөөц нь мал эмнэлгийн газрын нөөцтэй нэг тооцоотой байдаг.
2. Тусгай зориулалтын машин болон техник хэрэгсэл хангалтгүй /Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий/.
3. Мал эмнэлгийн нөөц бүрдүүлэлт дутагдалтай. Мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцийн нийт зардал 2022 оны байдлаар 4.104.321.615 төгрөг байгаа бөгөөд зарим зардал хэт их төвлөрсөн байна.

6. Амьд малд олгосон мал эмнэлгийн гэрчилгээний тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ /2020-2022 он/

Улсын хэмжээнд малын шилжилт хөдөлгөөнийг хянах, зарим арга хэмжээг сайжруулах зорилгоор 2020-2022 онд малд олгосон мал эмнэлгийн гэрчилгээний тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд:

- Малын шилжилт хөдөлгөөнд олгосон гэрчилгээ 2020 онтой харьцуулахад 64.8%-аар буурсан.
- Нийт бичигдсэн гэрчилгээний 79.4% нь хүнсний зориулалттай байна.
- 5-11 дүгээр сард малын шилжилт хөдөлгөөн ихээр хийгддэг.

- Улаанбаатар хот руу шилжилт хөдөлгөөн их.
- Хонь, ямаа үхрийн шилжилт хөдөлгөөн 90% тус тус эзэлж байна.

Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Мал эмнэлгийн гэрчилгээ олголт буурч байгаа шалтгааныг судлах, гэрчилгээнд тавих хяналтыг сайжруулах;
- Шилжилт хөдөлгөөн их хийгддэг 5-11 дүгээр сард мал эмнэлгийн хяналтын арга хэмжээг чангатгах;
- Малын шилжилт ихтэй аймаг, орон нутагтаа шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хянах чиглэлд ажлаа хамтран төлөвлөх;
- Отор нүүдэл, үзэсгэлэн худалдаа, үйлдвэрлэл худалдаа, үржлийн зориулалттай малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

МЭНС-ийг анх 2016 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар салбарын байгууллагуудыг хамруулсан 8 дэд системтэй болсон. МЭНС-ийн үндсэн системийн нэг болох мал эмнэлгийн гэрчилгээний системд 2020-2022 онд нийт 504.626 мал эмнэлгийн гэрчилгээ бүртгэгдэж, 11.636.056 толгой малын шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. Малын шилжилт хөдөлгөөнд олгосон гэрчилгээ 2020 онтой харьцуулахад 64.8%-аар буурчээ.

Гэрчилгээний зориулалтаас үзвэл, алдуул мал 14 (0%), отор, нүүдэл 54.121 (10.7%), үзэсгэлэн, уралдаан 10.438 (2.1%), үйлдвэрлэл, худалдаа 4.629 (0.9%), үржил 34.768 (6.9%), хүнсэнд 400.656 (79.4%) гэрчилгээ бичигдсэн байна.

Гэрчилгээг малын төрлөөр тооцвол, адуу 733.977 (6.3%), гахай 16.744 (0.14%), тахиа 263.061 (2.3%), тэмээ 42.180 (0.36%), үхэр 574.089 (4.9%), хонь 5.853.655 (50.3%), ямаа 4.150.759 (35.7%) толгойд бичигдсэн байна. Малын шилжилт хөдөлгөөн 5-11 дүгээр сард түлхүү хийгддэг байна.

7. Мал эмнэлгийн цахим гэрчилгээ (МЭЦГ)

2022 оны 1 дүгээр улиралд 4.243 ширхэг МЭЦГ-г үндэслэн 5.482 иргэн, аж ауй нэгжийн 5.1 сая литр сүүнд нийт 2.5 тэрбум төгрөгийн урамшууллыг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар олгосон. Сүүний урамшууллын систем болон мал эмнэлгийн гэрчилгээний системийг холбох ажлыг зохион байгуулснаар, 2022 оны 11 дүгээр сард 1.653 ширхэг МЭЦГ-г 1.816 иргэн, аж ахуйн нэгжийн 2.5 сая литр сүүнд нийт 1.2 тэрбум төгрөгийн урамшууллыг ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/398 дугаар тушаалаар тус тус олгосноор 2022 онд нийт 7.298 иргэн, аж ахуйн нэгжийн 7.3 сая литр сүүнд нийт 3.7 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед цагдаагийн 28 пост, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын 13 цэгээр дамжуулан шилжилт хөдөлгөөнийг хянаж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 4.952 гэрчилгээнд татгалзсан хариу өгч, 397.534 ширхэг МЭЦГ-г иргэн, аж ахуйн нэгжид олгож, 30.783 ширхэг цахим гэрчилгээг шалгаж баталгаажуулан, 715 ширхэг мал эмнэлгийн цахим гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгжийг саатуулан, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан байна.

МЭЕГ, Цагдаагийн ерөнхий газрын хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Мал мах–2022” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр

сард зохион байгууллаа. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хөдөө, орон нутгаас бэлтгэн нийлүүлж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгжид нийт 83.451 МЭЦГ-г баталгаажуулан цахимаар олгож, 54.544 МЭЦГ-г олгохоос татгалзаж, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын 17 цэг, постоор дамжуулан шилжилт хөдөлгөөний хяналт шалгалтыг явуулснаар Зөрчлийн тухай хуулийн 13.5, 13.9 дэх заалтыг үндэслэн, зөрчил бүхий 229 иргэн, аж ахуйн нэгжид мал эмнэлгийн улсын байцаагч 32.253.410.0 төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч, харьяалах Прокурорын газарт хянуулан, мал эмнэлгийн хяналт, шалгалтын орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Мөн энэ хугацаанд цагдаа, мал эмнэлгийн байгууллагаас 215 постод 591 албан хаагч, 183 тээврийн хэрэгсэлтэйгээр 24 цагийн турш ажиллаж, МЭЦГ-ний зөрчилтэй мал, мах тээвэрлэсэн 340 зөрчлийг илрүүлэн, 51.150.000.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, нийт 569 зөрчилд 86.403.410.0 төгрөгийн торгууль шийтгэвэр оноосон байна.

МЭЕГ, Цагдаагийн ерөнхий газрын хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хоёр байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу 21 аймаг, нийслэлийн Цагдаагийн хэлтэс, сумдын цагдаагийн 231 албан хаагчийг хамруулан, МЭНС-ийн цахим сургалтыг зохион байгуулав.

МЭЦГ-ний шинэчлэл: Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах зорилготой МЭНС-ийг 2022 онд шинэчлэн сайжруулж, систем 2.0 хувилбараар ашиглалтад оруулж байна.

Улмаар шинэчлэн сайжруулсан систем 2.0 хувилбарыг хүлээн авч, системийг танилцуулах, өөрчлөлт орсон хэсгүүдийн талаарх практик сургалтыг АНМЭГ, сум, дүүргийн МЭТ, МЭҮН-ийн 1672 эмч, албан хаагчдыг хамруулан, цахимаар зохион байгуулсан.

МЭНС хувилбар 2.0-т нэмэлтээр хийх ажлын даалгавруудыг боловсруулан, хариуцагч аж ахуй нэгж рүү илгээснээр 1.0 хувилбараас доорх үзүүлэлтээр давуу байна. Үүнд:

Гэрчилгээний тайлангаас мэдээлэл авахад хялбар болгох, системд өрх хасах эрх /нас барсан иргэн, өөр нэгжээр үйлчлүүлэх хүсэлт гаргасан малчин өрх гэх мэт/, тасгийн байцаагч тухайн хариуцсан дүүргийнхээ мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээний мэдээллийг гар утасны эрхээрээ хардаг болох /одоо тухайн арга хэмжээг төлөвлөж оруулсан тархвар зүйчийн эрхээр харагдаж байгаа/, тасгийн байцаагч тодорхой аж ахуйн нэгж, малчин болон мал бүхий иргэдийн мал эмнэлгийн гэрчилгээнд хорио цээрийн дэглэм, тандалт, шинжилгээний дүнг үндэслэн тодорхой хугацаагаар хориг тавих, мөн сэргээдэг байх /тухайн гэрчилгээ бичих МЭҮН-ийн малын эмчийн мэдээлэлд хориглосон үндэслэл, хугацаа харагддаг байх/, тайлан цэсээс дуудлагаар үйлчилсэн малын тоо нийт болон төрлөөр харагддаг байх зэрэг үзүүлэлтүүдийг нэмж, МЭНС-ийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

Ингэснээр МЭЕГ-т харьяалагддаг системүүдийг нэг домэйн хаягаас 9 саб домэйн үүсгэж, “Айтүүлс” ХХК-тай гэрээ байгуулан, SSL Wildcard нууцлал авч, аюулгүй байдлыг хангах ажлыг гүйцэтгэлээ.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлага

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөж эхлээгүй байх үед буюу 2018 онд аймгийн ХХААГ, Мал эмнэлгийн албаны даргаар ажиллаж байсан, удирдах ажилтны шалгалт өгсөн 8 удирдах албан тушаалтны аймгийн МЭГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон шийдвэрийг жинхлэн томилов.

Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Увс, Төв, Хөвсгөл аймгийн МЭГ-ын дарга нарыг сонгон шалгаруулах төрийн албаны тусгай шалгалтын захиалгыг ТАЗ-ийн ХХААХҮЯ-ны дэргэдэх салбарт зөвлөлд хүргүүлж, 8 МЭГ-ийн даргыг жинхлэн томилов.

ХХААХҮ-ийн сайдын 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн МЭГ, сум, мал бүхий дүүргийн МЭТ-ыг бүтэц, орон тоог шинэчлэн батлуулав.

2. Байгууллагын хүний нөөцийн удирдлага

ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/110, А/166 дугаар тушаалаар МЭЕГ-ын бүтэц, зохион байгуулалт 5 газар, 43 орон тоотойгоор шинэчлэн батлагдсан болно. Агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх 37 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ТАЗ-өөр батлуулсан.

Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн 10 мэргэжилтнийг албан тушаалд жинхлэн томилж, МЭЕГ-ын 9, нийслэлийн МЭГ-ийн 12 мэргэжилтнийг Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэв.

МЭЕГ-ын даргын 2022 оны 01/261 тоот албан бичгээр тус ерөнхий газрын албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгуулах саналыг хүргүүлснээс ХХААХҮ-ийн сайдын Б/08 дугаар тушаалаар 2 албан хаагчид дөтгөөр зэргийн дэс түшмэлийн зэрэг дэв шинээр, 1 албан хаагчид гутгаар зэргийн дэс түшмэлийн зэрэг дэвийг ахиулан олгов.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 39 иргэний ХАСУМ-ийг АТГ-т хүргүүлэн хянуулж, ирсэн дүгнэлтийг үндэслэн, 25 иргэнийг нийтийн албанд томилсноос гадна хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг мэдүүлэв.

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан

-Мал эмнэлгийн салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан: Мал эмнэлгийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын А/175 дугаар тушаалаар батлуулан МЭЕГ, АНМЭГ-ын 25 байгууллага, 77 нэгжийн 680 албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахим санд боловсруулж, тайлагнахад хяналт тавьж ажиллав. МЭЕГ нь 2022 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 33 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг төлөвлөж, тайлагнасан байна.

-Монгол Улсын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн гаргасан төлөвлөгөөний хэрэгжилт: Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан мал эмнэлгийн салбарт хамаарах нийт 232 арга хэмжээний хэрэгжилтийг цахим санд бүрэн тайлагнасан байна.

-Хагас жил, жилийн эцсийн бичмэл тайлан: АНМЭГ, харьяа байгууллага, МЭЕГ-ийн бүтцийн 5 нэгжийн хагас бүтэн жилийн үйл ажиллагааны бичмэл тайланг нэгтгэн архивлав.

-Долоо хоногийн ажлын тайлан: МЭЕГ болон АНМЭГ, харьяа байгууллагын үйл ажиллагааны тайланг ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т товлосон хугацаанд нь, 48 удаа хүргүүлэн ажилласан байна.

4. Салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт

ХХААХҮ-ийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын 37 шуурхай хуралдааны нийт 81 үүрэг даалгаврын биелэлтийг жилийн эцсийн байдлаар 100 хувь тайлагнасан байна.

МЭЕГ-ын даргын шуурхай хуралдаан

Тайлант хугацаанд МЭЕГ-ын даргын 36 удаагийн шуурхай хуралдааныг хуралдуулж, 445 үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох албан тушаалтнаар хангуулж ажиллав.

5. Шагнал, урамшуулал

- МЭЕГ-ын “Хүндэт өргөмжлөл”-ийн тодорхойлолт, загварыг МЭЕГ-ын даргын А/126 дугаар тушаалаар батлуулан, мал эмнэлгийн салбарт олон жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж, ажлын дадлага туршлага, ур чадвараараа хамт олноо манлайлан ажилласан 256 албан хаагчийг шагналд нэр дэвшүүлснээс 105 албан хаагчийн шагналыг олгуулан ажиллав.

6. Өргөдөл, гомдолд хариу өгөх үйл ажиллагаанд хяналт тавих

Иргэн, хуулийн этгээдээс 115 өргөдөл, гомдол ирсний 92 хувь нь бүрэн шийдвэрлэгдсэн, 8% хувь нь судлагдаж, шийдвэрлэгдэх шатанд байна. Нийт өргөдлийн 2(1.7%) нь хүсэлт, 3(2.6%) нь санал, 5(4.3%) нь гомдол байв. Нийт өргөдлийн 60.8 хувь (70)-ийг хүний нөөцтэй холбогдох асуудал эзэлж байгаа бөгөөд 17.3 хувь буюу 20 өргөдөл нь мал эмнэлгийн ажил үйлчилгээний доголдлын талаар үлдсэн 10 хувь (25) нь бусад асуудлыг хөнджээ.

6. Дотоод хяналт шалгалт

МЭЕГ болон харьяа 24 байгууллагад шилэн дансны хууль хэрхэн хэрэгжиж буйг сар бүр хянаж шалган, тайлан мэдээг улирал бүр ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. Төрийн аудитын байгууллагаас МЭЕГ болон Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх хүрээний 24 байгууллагад 2021 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд өгсөн 11 акт, 37 албан шаардлага, 44 зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллав.

7. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

ДМАЭМБ-ын 89 дүгээр чуулганаар үеэр 2021 оны үхрийн цээж өвчний доссиргийг баталж, Монгол Улсыг үхрийн цээж өвчнөөс ангид улсаар баталгаажуулав. ДМАЭМБ болон бусад хамтрагч олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр дараах хурал хэлэлцүүлгийг Монгол Улсад зохион байгуулав. Үүнд:

- Олон улсын эрүүл мэндийн дүрэм, мал эмнэлгийн тусламж үйлчилгээний урсгалыг холбох салбар хоорондын хамтарсан “Нэг эрүүл мэнд” үндэсний сургалт;
- "Монгол Улсын Мал эмнэлгийн албаны гүйцэтгэлийн ахиц дэвшилд 2019 онд хийсэн үнэлгээнээс гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх" оролцогч талуудын хамтарсан хэлэлцүүлэг;
- ДМАЭМБ болон Зэрлэг амьтан хамгаалах олон улсын зөвлөл (СIC)-тэй хамтран "Зэрлэг амьтны өвчний тандалт судалгаа" сэдэвт олон улсын зөвлөгөөн зэрэг хамаарах юм.

ОХУ-ын Бүх холбоотны Мал, амьтны эрүүл мэндийн төвийн судлаачидтай мал, амьтны гоц халдварт өвчний асуудал, Вьетнам Улсын ХАА, хөдөөгийн хөгжлийн яамны МАЭМГ-ын төлөөлөгчидтэй Монгол Улсаас хонь, ямааны мах экспортлох асуудлаар тус Улсад хүлээн авч, хамтран ажиллав.

МЭЕГ-ын дарга ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24 дүгээр хурал, БНФУ-ын Монтфеллиер хотноо зохион байгуулагдсан Хил дамжин

халдварладаг мал, амьтны халдварт өвчний хяналт (GF-TADs) санаачилгын хүрээнд “БММӨ-ий судалгаа, шинжилгээ, мэргэжлийн сүлжээ” (PPR-GREN)-ний тус тус оролцов.

9. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах

- “Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, Мал эмнэлгийн салбарын бодлого үйл ажиллагаа болон заавар, чиглэл, зөвлөмжийг байгууллагын цахим www.vet.gov.mn 92, “Мал эмнэлгийн ерөнхий газар” нүүр хуудсаар 237 мэдээ, мэдээлэл нийтэлж, Мал эмнэлгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, сайт, сонин, сэтгүүлд цацагдсан нийт 392 мэдээллээр цахим архив үүсгэв.
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах 5 гэрээ байгуулж, МҮОНРТ-ийн хамтран 18 сэдвээр Эрүүл мал-Монголын баялаг нэвтрүүлэг, мал, амьтны халдварт болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 видео шторкийг бэлтгэн, нийтэд хүргэсэн.
- Мал эмнэлгийн салбарын цаг үеийн ажлаар хэлэлцүүлэг, зочны цагаар нийт 7, бусад хэвлэл мэдээллийн байгууллагаар 280 гаруй мэдээ, мэдээллийг хүргэж, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тэжээлийг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн бүрдүүлэх материалын мэдээллийг 356 иргэдэд өгч ажилласан.

10. Архив, албан хэрэг хөтлөлт

МЭЕГ-ын даргын А-130, Б-54 нийт 184 тушаалыг албажуулж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, РРТ болгон цахим сан үүсгэн хадгалж байна. 2022 онд МЭЕГ-т нийт 5647 албан бичиг хүлээн авч, 1360 албан бичгийг илгээсэн байна.

Ирсэн баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, явуулах баримт бичгийг бүртгэх, өргөдөл гомдлыг бичиг хэргийн бүртгэл, хяналтын программд бүртгэн, хяналтын карт хөтлөн баталгаажуулав.

САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

1. Мал эмнэлгийн салбарын төсөв

- МЭЕГ нь 2022 оны урсгал зардлын төсвийн хүрээний мэдэгдлийг Сангийн яамны Fiscal.B онлайн системд оруулж, хянан баталгаажуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн СХОГ-т 2021 оны 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлсэн. Тус газар нь 2022 оны шаардлагатай арга хэмжээний зардалд 44.7 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргэж, 32.2 тэрбум төгрөгөөр УИХ-аар шийдвэрлэгдсэн ч Төсвийн тухай хуульд тодотгол орсонтой холбогдуулан, арга хэмжээний зардлыг 27.0 тэрбум төгрөгөөр батлуулсан байна.
- МЭЕГ болон АНМЭГ, НМЭГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ-ийн 2022 оны үйл ажиллагааны урсгал зардал 19.1 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд уг зардлын зарцуулалтыг ХХААХҮ-ийн салбарын төсвийн хяналтын нэгдсэн онлайн систем (<https://www.opengov.mn/>)-д төсвийн тухай хуулийн дагуу сар, улирлаар тайлагнасан байна.
- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022 онд 23.5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд хагас жилээр 100% гүйцэтгэлтэй зарцуулсан байна.
- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас Биокомбинат ТӨХХК-д 2.757.1 сая төгрөгийн эм биобэлдмэлийн үнэ олгохоос 1.731.6 сая төгрөг, гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 12.0 сая.тун вакцин худалдан авахад 8.856.5 сая төгрөг, гоц халдварт мяззан, үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины зардалд 706.7 сая төгрөг, лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн худалдан авахад нийт 1.321.1 сая төгрөг төлөвлөгдөж, худалдан авалт 100% хийгдэж, гэрээ дүгнэгдэн 152.0 сая төгрөгийг тус тус олгоод байна.
- Малын өвчний дуудлага бэлэн байдлыг хангах дотоод томилолтын зардалд 85.8 сая төгрөг батлагдаж, 38.7 сая төгрөг зарцуулсан байна.
- АНМЭГ-т гоц халдварт өвчний үйлчилгээний хөлс 3.234.4 сая төгрөгийг олгосон байна. Малын халдварт өвчний үйлчилгээний хөлсөнд 1.824.5 сая төгрөгийг 5 сарын төсвийн зохицуулалт хийж олгосон бөгөөд бусад ариутгал халдваргүйтгэл, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл зэрэг зардалд нийт 2 тэрбум төгрөгийн төсвийн зохицуулалт хийсэн байна.

2. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагаа

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын А-48 тоот тушаалаар батлуулж, 8 бүлэг, 12 багц тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Худалдан авах ажиллагаанд зарцуулах нийт батлагдсан төсөв 13.8 тэрбум төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 100% гүйцэтгэлтэй зарцуулсан байна.

3. Мал эмнэлгийн салбарын үндсэн хөрөнгийн өөрчлөлт

- Мал эмнэлгийн салбарт 2022 онд 1.056.635.875 төгрөг 30 мөнгөний үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Үүнд: Төсвийн хөрөнгөөр 6.339.400 төгрөг, төслөөс үнэ төлбөргүйгээр 553.743.804 төгрөг 05 мөнгө, Төрийн өмчийн хорооны бодлого зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын 2022 оны 494 дүгээр тогтоолоор 485.877.671 төгрөг 25 мөнгөний хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, 5.000.000 төгрөгийн хөрөнгийг нэмэлт санхүүжилтээс, дахин үнэлгээгээр хөрөнгийг үнэлгээг 5.675.000 төгрөгөөр нэмэгдүүлснээр тус тус өссөн байна.
- Хөрөнгийн зарцуулалтын хувьд 33.092.545 төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд АНМЭГ, МЭЭСБУЛ, УМЭАЦТЛ-оос ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгө актлах хүсэлтийг авч шалган, салбарын хэмжээнд нэгтгэж, Говьсүмбэр, Булган, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар аймгийн МЭГ, МЭЭСБУЛ зэрэг 7 байгууллагын ирүүлсэн үндсэн хөрөнгийн жагсаалтыг холбогдох баримтыг үндэслэн, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй машин тоног төхөөрөмжийн данснаас 140 ширхэг 125.406.895.18 мөнгөний анхны өртөгтэй машин тоног төхөөрөмжийг, тавилга эд хогшлын данснаас 63 ширхэг нийт 6.028.314.65 төгрөгийн анхны өртөгтэй тавилга эд хогшил, үлдэх өртөггүй хөрөнгийг данснаас хасах хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлэв.
- Говьсүмбэр, Булган, Дундговь, Сүхбаатар аймгийн МЭГ-ын элэгдлийг хугацаа дууссан, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах болон дахин үнэлэх хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлэв.
- Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өмнөговь аймгийн МЭГ, УМЭАЦТЛ нийт 5 байгууллагын 8 ширхэг 211.765.914.04 анхны өртөг бүхий ашиглалтын хугацаа дууссан авто тээврийн хэрэгсэл актлах хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлэв.
- ТӨБЗГ-ын даргын 2022 оны тогтоолоор Монгол Улсын төрийн эд хөрөнгийн тооллогыг хийх шийдвэрийн дагуу МЭЕГ-ын даргын 2022 оны А/128 тоот тушаалаар эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж, өмч хамгаалах ажлын хэсэгт хөрөнгийн элэгдэл, ашиглалт хамгаалалтын талаар тайлагнав.